

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-42

1.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

5-20

2.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

20-34

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс ирүүлсэн татан буугдсан “Зоос банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн асуудлаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх Монголбанкны мэдээллийг сонсох

34-42

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
3 дугаар сарын 31-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 47 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Анар, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, С.Цэнгүүн;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан, Э.Одбаяр, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, мөн яамны Хөрш орнуудын газрын захирал Т.Жанабазар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт М.Мандхай нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Уянга, Ч.Лодойсамбуу нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, М.Энхцэцэг, Р.Сэддорж нар үг хэлэв.

Р.Сэддорж: Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга И.Лувсанцэрэн, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа, мөн компанийн Судалгаа хөгжүүлэлт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Уянга, М.Энхцэцэг, М.Мандхай, Х.Булгантуяа, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга И.Лувсанцэрэн, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, М.Энхцэцэг, Б.Жавхлан нар үг хэлэв.

Р.Сэддорж: Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс ирүүлсэн татан буугдсан “Зоос банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн асуудлаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх Монголбанкны мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Амгалан, мөн банкны Хууль, эрх зүй газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн дарга Б.Эрдэнэхуяг, иргэн Б.Цэрэнжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү иргэн Б.Цэрэнжаваас ирсэн өргөдлийн талаар танилцуулав.

Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Амгалан, өргөдөл гаргагч иргэн Б.Цэрэнжав, Монголбанкны Хууль, эрх зүй газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн дарга Б.Эрдэнэхуяг нар татан буугдсан “Зоос банк” ХК-ийн талаар мэдээлэл, тайлбар хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын тавьсан асуултад Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Амгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү үг хэлэв.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн гаргасан, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн “Зоос банк” ХК-ийг 2009 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр албадан татан буулгасан үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл болон хувьцаа эзэмшигч иргэдийн эрхийг хамгаалах асуудлаар хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 18
Бүгд: 22
18.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүд татан буугдсан “Зоос банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн асуудлаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Амгалан, мөн банкны Хууль, эрх зүй газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн дарга Б.Эрдэнэхуяг нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 16 минут үргэлжилж, 31 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 71.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 47 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Өнөөдөр хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батчимэг, Ганзориг, Заяабал, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Найдалаа, Очирбат, Соронзонболд, Сэддорж, Уянга, Энх-Амгалан, Энхцэцэг, Үүрийнтуяа нарын Улсын Их Хурлын гишүүд оролцож байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдааны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 54.8 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төсөл, Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

2.Монгол Улс олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-4” төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэх, Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

3.Татан буугдсан “Зоос банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчидтэй холбоотой асуудлаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл сонсох.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж өөр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 1.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Г.Дамдинням: Байнгын хорооны эрхэм гишүүд, даргын энэ өдрийн мэндийг эрье.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын суурьшил сийрэг, далайд гарцгүй манай орны хувьд агаарын тээврийн салбар нь гадаад ертөнцтэй холбогдох гол гарц болон үндэсний аюулгүй байдлын тулгуур хүчин зүйл болдог. Иймээс Засгийн газраас агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар манай улс агаарын хөлгийн түлшийг 100 хувь Оросын Холбооны Улсаас импортолж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд ТС-1 агаарын хөлгийн түлшний хэрэглээ тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Тухайлбал, 2022 онд 38.4 мянган тонн байсан бол 2025 онд 84.3 мянган тонн хүрч 2 дахин нэмэгдсэн байна. Монгол Улсад агаарын хөлгийн үйлчилгээ эрхэлж буй дотоодын 20, гадаадын 7 буюу нийт 27 авиа компани байгаагаас 2025 онд нийтдээ олон улсад 2 сая зорчигч, орон нутагт 442.2 мянга буюу нийт 2 сая 448415 зорчигч тээвэрлэсэн байна. 2024 онтой харьцуулахад олон улсын чиглэл 15 хувь буюу 259 мянган зорчигчоор, орон нутгийн чиглэл 5 хувь буюу 21 мянган зорчигчоор тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Ачаа, тээврийн хувьд 2025 онд 12.3 мянган тонн ачаа 187.6 тонн шуудан тээвэрлэсэн үзүүлэлттэй байна. 2024 онтой харьцуулахад ачаа 21 хувиар өссөн бол шуудан 16 хувиар буурсан байна. Аялал жуулчлал, эдийн засгийн идэвх нэмэгдэж байгаа нь 2028 он хүртэл зорчигч ачаа тээвэрлэлт тогтвортой өсөлттэй байх төлөвтэй бөгөөд агаарын тээврийн зорчигч тээврийн тоо 2025 онд 2.4 саяд хүрсэн бол 2028 онд 2.5 сая хүрэх төлөвтэй байна. Энэхүү өсөн нэмэгдэх хандлагатай агаарын хөлгийн түлшний хэрэглээг зах зээлийн боломжит доод үнээр нийлүүлснээр хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалахаас гадна иргэдэд хүрэх нислэгийн тийзийн үнэ буурахад тодорхой хувиар нөлөөлөл үзүүлэх боломжтой юм.

Агаарын хөлгийн тээврийн үйлчилгээ авч буй иргэдэд хүрч буй тийзийн үнийн 36 орчим хувь нь агаарын хөлгийн түлшний үнээс, харин агаарын хөлгийн шатахууны үнийн 86 орчим хувь нь хил үнээс тус тус шууд хамаарч байна.

Манай орон хөрш 2 улстай хуурай боомтоор хиллэдэг, далайд гарцгүй орны хувьд агаарын тээвэр нь чухал ач холбогдолтой бөгөөд агаарын хөлгийн түлшийг Оросын Холбооны Улсаас төмөр замаар их хэмжээгээр Улаанбаатар хот хүртэл тээвэрлэх боломжтой.

Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас онгоцны түлш худалдан авахад авахад төмөр замын царигийн зөрүүтэй байдлаас шалтгаалан Замын-Үүд боомтоор шилжүүлэн ачих байгууламжаар дамжуулан авах бөгөөд одоогоор онгоцны түлшийг хадгалах зориулалтын сав, насос станц, дотоодын тусгай вагонцистерн байхгүй байна.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас нийлүүлэгдэх онгоцны түлш стандартын хувьд JETA түлш бөгөөд өнөөдөр ашиглалтад ороод байгаа шинэ нисэх буудлын шатахууны хангамжийн байгууламжид TS1 агаарын хөлгийн түлшинд хамтад нь ашиглах технологийн шийдэл анхнаасаа төлөвлөгдөөгүй байна.

Цаашид дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ болон Оросын Холбооны Улсын газрын тосны бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн нөхцөл байдалтай холбогдуулан Оросын Холбооны Улсын Засгийн газраас экспортын хязгаарлалт хийх, татвар нэмэгдүүлэх шийдвэр гарч болзошгүй бөгөөд энэ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт тэр дундаа агаарын хөлгийн түлшний нийлүүлэлтэд нөлөөлж хомсдол үүсэх болзошгүй байдал орж байна.

Иймд Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийг тасралтгүй үргэлжлүүлэх, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой нийлүүлэх боломж бүрдэх юм.

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч Оросын Холбооны Улсын зүгээс агаарын тээврийн салбарт хамтран ажиллах талаар өмнө нь удаа дараа хүсэлтээ илэрхийлээд ирсэн бөгөөд Монгол Улсад Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путины албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж, Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан болон Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Сергей Евгеньевич Цивилев нар урьдчилсан байдлаар гарын үсэг зурсан байна.

Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу Монгол Улсад агаарын түлш нийлүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Улсын хэлэлцээрийг Улсын Их Хурлын Байнгын байнгын хороогоор Улсын Их Хурлын гишүүдийн саналыг нэгтгэн 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 01-19 дугаартай албан бичгээр Оросын Холбооны Улсын Эрчим хүчний яаманд хүргүүлсэн.

Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайдаас 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хэлэлцээрт оруулах өөрчлөлтөд татгалзаж хэлэлцээрийг яаралтай эцэслэх Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр нь хамтдаа хүчин төгөлдөр үйлчлэх талаар дурдсан албан бичгийг ирүүлсэн юм.

Үүнтэй холбогдуулан 2025 оны 9 дүгээр сард Оросын Холбооны Улсын Владивосток хотод зохион байгуулагдсан Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хувиар уг хэлэлцээрт тусгах өөрчлөлтийн асуудлаар Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Сергей Евгеньевич Цивилев, Байгалийн нөөц, экологийн сайд, Монгол, Оросын Засгийн

газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга Александр Александрович Козлов нартай уулзалт хийсэн. Мөн оны 10 дугаар сард Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төлөөлөл Оросын талын итгэмжлэгдсэн байгууллага байгууллага болох “Роснефть” нөхөрлөлийн компани, удирдлагуудтай уулзан холбогдох асуудлаар тохиролцож зөвшилцөлд хүрсэн.

2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Оросын Холбооны Улсын Эрчим хүчний дэд сайд П.Ю.Сорокинтой цахим хурал хийж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо гишүүдээс өгсөн саналыг Оросын талд хүргүүлсэн, дахин хүргүүлсэн.

Мөн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Шанхайн хамтын ажиллагааны уулзалт арга хэмжээний үеэр Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Сергей Евгеньевич Цивилев, Байгалийн нөөц, экологийн сайд Монгол, Оросын Засгийн газрын хоорондын комиссын Оросын хэсгийн дарга Александр Александрович Козлов нартай Москва хотод уулзаж, газрын тосны импортын хэмжээг нэмэгдүүлэх, агаарын хөлгийн түлшний хэлэлцээрт тусгах Монголын талын тавьсан саналын талаар санал солилцсон.

2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн цахим хурлын үеэр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням Оросын Холбооны Улсын Эрчим хүчний дэд сайд П.Ю.Сорокинтой хэлэлцээрт оруулах Монголын талын тавьсан 7 саналыг тусган өөрчлөн найруулсан протоколын төслийг танилцуулсан.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням 2026 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр албан томилолтын хүрээнд Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Сергей Евгеньевич Цивилев, Эрчим хүчний дэд сайд П.Ю.Сорокинтой нартай Москва хотод уулзаж газрын тосны бүтээгдэхүүнийг урт хугацаанд тогтвортой нийлүүлэх, агаарын хөлгийн түлшний хэлэлцээрийн сүүлийн хувилбарыг тохироод байна.

Дээрх уулзалтуудын дүнд Оросын Холбооны Улсын Эрчим хүчний яамнаас 2026 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт оруулах өөрчлөлтийн протоколын эцсийн хувилбарыг ирүүлсэн тул Олон улсын гэрээний тухай хууль болон Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд нийцүүлэн үндсэн хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг 1 багц болгон Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр бэлдээд байна.

Хэлэлцээрт орсон өөрчлөлтүүдийн тухайд,

Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт цогцолборыг удирдах, ашиглах, үйл ажиллагаа явуулна гэсэн нисэх буудлыг бүхэлдээ удирдах гэсэн хоёрдмол утгыг илэрхийлж байсан тул хэлэлцээрийн өөрчлөлтийн нэмэлт протоколд энэ асуудлыг тодорхой тусгаж, талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх буудлын агаарын хөлгийн түлшээр цэнэглэх дэд бүтцийг цаашид байгууламж гэх удирдах болон ашиглах хамтарсан компани байгуулна гэж Монголын талын саналаар өөрчлөлт оруулсан.

Өөрөөр хэлбэл, бүх л байгууламжийн хүрээнд биш зөвхөн цэнэглэх байгууламжийн хүрээнд гэж тодотгож өгсөн. Энэ чуулганы хуралдааны үеэр бас асуудал яригдаж байсан.

5 дугаар заалтад Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоодын зах зээлд газрын тосны бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана гэж заасныг нь газрын тосны бүтээгдэхүүн гэж бүх төрлийн шатахууныг хамруулсан утгатай заалт орсон тул тодруулах, хуульд нийцүүлэх зорилгоор Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоодын зах зээлд агаарын хөлгийн түлш борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана гэж Монголын талын саналаар оруулсан болно. Өөрөөр хэлбэл, зөвхөн агаарын хөлгийн түлшний хүрээнд энэ хэлэлцээрийг хийнэ гэсэн тодотголыг хийсэн.

Хэлэлцээрт өөрчлөлт оруулах замаар нэмэлт протоколын төслийг хэлэлцэх явцад Монголын тал 7 дугаар зүйл нь бүхэлд нь хасах саналыг тавьсан. Хэлэлцээрийн явцад Оросын талаас 7 дугаар зүйл нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг хадгалах үүднээс олон улсын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрт зайлшгүй тусгагддаг тул хасах боломжгүй гэдэг байр суурийг сайд нарын уулзалтууд дээр тогтмол илэрхийлж байсан.

2026 оны 11 дүгээр сард Москва хотноо болсон ШХАБ-ын орнуудын уулзалтын үеэр Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч мөн уг байр суурийг бататган илэрхийлсэн болно.

Хэлэлцээрийн явцад 7 дугаар зүйлийн 1 дүгээр догол хэсэгтэй давхацсан утгыг илэрхийлж байгаа тул 2 талаас зөвшилцсөний үндсэн дээр 2 дугаар догол хэсгийг хассан.

Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 2 дугаар догол хэсэгт орсон талын арбитрын шүүх маргаан таслахаар тусгагдсан нь Оросын талын арбитрын шүүх маргааныг таслахаар тусгагдсан нь зохимжгүй тул гуравдагч орны арбитрын шүүхээс сонгох саналыг Монголын талаас гаргаж, хэлэлцээрийн явцад Оросын талаас Беларусын Худалдаа аж үйлдвэрийн танхимд “International arbitration court ... CCI”-ийн дэргэдэх Олон улсын арбитрын шүүхийг санал болгосон.

Бүгд найрамдах Беларус улстай манай улс нь найрамдалт харилцаатай түншлэлийн гэрээ бүхий улс тул үгүйсгэх шалтгаан байхгүй тул хүлээн зөвшөөрсөн. Гадаад хэргийн яамнаас бас тодруулж энэ улсыг бас сонгосон. Манай талын тавьсан санал Бүгд Найрамдах Казакстан Улсыг санал болгож байсан.

Хэлэлцээрийн 11 дэх хэсэгт Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд үйлчилж буй ижил асуудалд зохицуулсан бусад 7 улсын хэлэлцээрээс давуу эрхтэй байна гэсэн заалт орсон нь олон улсын эрх зүйн акт, хэм хэмжээг үгүйсгэж давж үйлчлэх утгатай Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй байсан тул Монголын талын саналаар удаа дараа ярилцсаны үр дүнд хассан.

Мөн Оросын талаас хэлэлцээрийн анхны хувилбарт 20 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх заалттай байсан тул Монголын талаас 5 жил болгох саналыг тавьсан. Гэвч Оросын тал хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны тогтвортой байдлыг хангах гол хөшүүрэг нь урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ тул хугацааг бууруулахгүй байх байр суурийг илэрхийлсэн.

Хэлэлцээрийн явцад 15 жил болгож хугацааг богиносгосон өөрчлөлтүүдийг тус тус оруулаад байна. Энэхүү хэлэлцээр нь Монголын тал хуульд заасан дотоодын процедурыг хангаж, зохих шийдвэр гаргасны дараа үйлчилж эхлэх бөгөөд тус хэлэлцээрт агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлт, татварын тогтвортой байдалтай холбоотой заалтууд орсон байх тул Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд Байнгын хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулах шаардлагатай байгаа юм.

Оросын Холбооны Улсын зүгээс энэхүү 2 хэлэлцээр хамтдаа хүчин төгөлдөр үйлчлэх талаар мэдэгдсэн бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангахын тулд Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах нь чухал ач холбогдолтой юм гэж үзэж энэхүү хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтөд гарын үсэг зурах зөвшөөрлийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөх, холбогдох шийдвэрийг гаргуулахаар танилцуулж байгааг хүлээн авна уу.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Гонгорын Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын үүрэг гүйцэтгэгч, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Жамбалдоржийн Соёлмаа Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал, Түвдэндоржийн Жанабазар Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирал.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Асуулт асуух гишүүд Лодойсамбуу гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ цаг үед бас чухал асуудал орж ирж байгаа бас бидэнд хэрэгтэй өөрчлөлтүүд тусгагдаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд яг энэ танилцуулсан танилцуулгатай холбоотой орж байгаа өөрчлөлттэй холбоотой 2 асуулт байна.

Нэгдүгээрт, хэлэлцээрийн энэ 7-гийн 2 дахь догол мөр гээд байгаа тээ? Тарифын татвар хураамжтай холбоотой, квоттой холбоотой мөн хууль тогтоомжийн өөрчлөлтөөр олгож байсан хөнгөлөлт, энэ давуу эрх 2 талдаа харилцан адилхан үйлчлэх байсан энэ заалтыг хасаж байна л даа. Тэгээд эндээс ямар үр дүн гарна гэж тооцож байгаа вэ? Ер нь ямар үр дүн гарах вэ? Эерэг болон сөрөг талаас нь бас харж байгаа өнцгөөс нь тайлбарлаж өгөөч гэж хүсэж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Оросын Холбооны Улстай газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах яриа хэлцэл амжилттай хийгээд ирсэн. Энэ яриа хэлцлийн араас Оросын Холбооны Улс дахиад мэдэгдэл гаргачихлаа. Шатахууныхаа, газрын тосны бүтээгдэхүүнийхээ импортыг хязгаарлачихлаа. Олон улсад үүсэж байгаа энэ сорилт, нөхцөл байдалтай холбоотойгоор дотоодын нөөцөө илүү их бүрдүүлэх тал дээр бодлого бариад эхэллээ. Тэгээд энэ дээр манайх хязгаарлалтад орохгүй гэдэг ийм зарим мэдээ, мэдээллүүд яваад байна л

даа. Энэ дээр яг албаны байр суурь ямар байгаа юм. Энэ талаар хэлэлцээд тохиролцоод хийсэн зүйл юу байна? Энэ мэдээллийг өгөөч. Баярлалаа.

Р.Сэддорж: Дамдинням сайд, үүрэг гүйцэтгэгч.

Г.Дамдинням: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт, би сүүлийн асуултаас нь эхлээд хариулъя. Оросын Холбооны Улсын зүгээс өнгөрсөн жилээс эхлээд АИ-92 авто бензин болон дизель түлш дээр 2 тусдаа тогтоол гаргаж, хориглолт, хориг, экспортын хориг тавьсан. Хэдийгээр бид энэ газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх, тогтвортой нийлүүлэх тухай хэлэлцээр 36 жилийн хугацаанд байгуулаагүй, хүчин төгөлдөр мөрдөхгүй байгаа ч сайн хөршийн харилцаа, мөн бас Засгийн газрын идэвхтэй ажиллагааны үр дүнд бид энэ хязгаарлалтад орохгүй. Орохгүй ингэж явсаар байгаад өдий хүрч байна.

Хууль, эрх зүйн хувьд агаарын хөлгийн түлшний нийлүүлэх гэрээ Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн тогтвортой нийлүүлэх тухай хэлэлцээр хоёр хоёулаа хүчин төгөлдөр гарын үсэг зурж байж зэрэг мөрдөгдөнө өө гэдэг нөхцөлийг Оросын Холбооны газраас тавьдаг. Бид нийт хэрэглээнийхээ 98 хувийг Оросын Холбооны Улсаас авдаг. 98 хүртэл хувийг.

Би Оросын Холбооны Улсын Монгол Оросын Засгийн газар хоорондын комиссын дарга Оросын Холбооны Улсын байгалийн нөөцийн сайд Александр Александрович Козловтой өөрийн биеэр бас уржигдар холбоо тогтоож ярьсан. Мөн бас Элчин сайдын яамнаас дахиж холбогдсон. Тэндээс надад өгсөн мэдээлэл бол Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч ч Владимир Владимирович Путины шийдвэрээр манай улс энэ хязгаарлалтад орохгүй гэдэг ийм шийдвэр гаргаснаа бид нарт танилцуулсан.

Бид энэ гэрээ хэлцлээ ингээд албажуулчихвал ямар нэг байдлаар эрх зүйн хувьд бид тэр импортлогч улсаасаа шаардлага тавих боломжтой гэж үзэж байгаа.

7.2-ын тэр догол мөртэй холбоотой асуудал бол манай улсын гол асуудлуудын нэг байгаа. Юу вэ гэхээр хөрш орнуудтайгаа болон хөрөнгө оруулагч орнуудтай гэрээ хэлцэл хийчхээд дараа нь хууль дүрмээ өөрчлөөд шинээр татвар хураамж тавьж маргаан үүсгэдэг асуудлыг арилгая. Тэгэхээр энд оруулж байгаа гол өөрчлөлт бол энэ хэлэлцээр нь, энэ хэлэлцээр байгуулагдсан цагаас хойш Монгол Улсын гаргасан хууль тогтоомж үйлчлэхгүй шүү гэж олон улсын гэрээ хэлцлийн олон улсын зарчимд нийцүүлбэ гэдэг утгатай ийм л өөрчлөлт орж байгаа. Энэ нь бол бас харилцан, ойлголцсон энэ олон улсын гэрээ хэлцлийн зарчмынхаа хүрээнд зөв зүйтэй ийм л зарчим байдаг. Гэрээгээ хийе л гэж байгаа юм. Тодорхой болгож оруулаад Их Хурлаас баталгаа авъя гэж байгаа юм.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Тэр 7.2 догол мөртэй холбоотой би яг энэ жишээлбэл Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөхгүй явснаараа бидэнд ямар нэгэн сөрөг үр дагавар үүсэх үү? Тэр дээр л тодорхой хариулж өгөөч.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн индрийн микрофон. Гадаад хэргийн яам индэр.

Ж.Соёлмаа: Сайн байцгаана уу? Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Соёлмаа байна. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд тохирсон хэлэлцээр дээр болохоор та бүхний мэдэж байгаагаар 2 заалт байсан. Нэг нь болохоор нөхцөлийг дордуулахгүй.

Хоёрт нь болохоор тариф, хураамж, үүний дотор гааль, бусад төрлийн татвар нэмэгдэх зэрэг мөн гадаадын ажилчдын квот нэмэгдэх зэрэг энэнтэй холбоотой бүхий л зохицуулалт дээр өөрчлөлт орсон. Өөрчлөлт орох боломжгүй. Энэ хэлэлцээрт хамаарахгүй гэсэн ийм 2 заалттай ийм хэлэлцээр байсан.

Сайдын хэлснээр энэхүү хэлэлцээрийн 2 заалтын 2 дахь догол мөрийг арилгасан. Өөрөөр хэлбэл, энэ тарифтай, квоттой болон татвар хураамжтай холбоотой энэ заалтууд дээр энэ хэлэлцээрээр зохицуулсан зүйл байхгүй. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд гэх юм бол татвар хураамж, үүний дотор гааль болон албан татвар, бүх гадаадын ажилчдадаа ногдуулах квоттой холбоотой зохицуулалт нь болохоор.../минут дуусав./

Р.Сэддорж: Индрийн микрофон гүйцээж хариулья.

Ж.Соёлмаа: Зохицуулалт нь нэгдүгээрт дотоодын хууль тогтоомжийн дагуу зохицуулагдахаар болсон. Шинэ нэмэлт, өөрчлөлтөөр.

Хоёрдугаарт, 2 улсын нэгдэж орсон Дэлхийн худалдааны байгууллагын тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн дагуу асуудал зохицуулагдахаар ийм шинэ зохицуулалтыг оруулж ирсэн.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Үүрийнтуяа гишүүн дахин тодруулья.

Д.Үүрийнтуяа: Би яг л тодорхой асуугаад байгаа байхгүй юу. Ийм өөрчлөлт ороод байгааг хараад байна шүү дээ. Ингэснээрээ ямар сөрөг үр дагавар байна вэ, эсвэл огт ямар ч нөлөөгүй юм уу манай дээр? Ямар нэгэн эрсдэл байна уу урьдчилан харж байгаа зүйл байна уу л гэж асуугаад байгаа юм.

Р.Сэддорж: Индэрийн микрофон.

Ж.Соёлмаа: Энэхүү 7 дугаар зүйлийн дагуу бол одоо бид нар 2 дугаар догол мөрийг хассанаар эерэг өөрчлөлтүүдийг авчирсан. Сөрөг өөрчлөлт гэх юм бол мэдээж хэрэг бид нар тэр чигээрээ энэ 7 дугаар зүйлийг хасахаар Оросын талтай хэлэлцээ хийсэн боловч үр дүнд хүрч чадаагүй. Тэгэхээр энэ 1 дүгээр догол мөр буюу нөхцөл байдлыг дордуулахыг хүргэсэн бол үйлчлэхгүй гэсэн ийм заалт л байгаа. Тэгэхээр энийг бол цаашид сөрөг байдлаар үүсэж болох нөхцөл байдал гэж бас урьдчилж харж болно.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Ер нь түлшний асуудал Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр ингээд байгаа. Та хэд маань уул нь уул уурхай, аж үйлдвэр салбартаа бодлого боловсруулах ёстой боловч манай онцгой нөхцөл байдлаас болоод аягүй их тийм төвөгтэй геополитикийн нөхцөл байдалд үеийн үед байдаг. Тэгэхдээ сүүлийн хэдэн сард ажиглаж байгаагаар дотор нь ажиллаж байсан хүний хувьд нэлээн сайн маневр хийж байгаад нь бас талархалтай хандаж

байна. Тэгээд удахгүй манай шатахууны үйлдвэр ашиглалтад ороод тэгээд тэр сайдын харилцаагаа эхлүүлсэн байсан жижиг үйлдвэрүүдийг бас дэмжээд явчихвал бас бага бага гаргалгаа нь гарах байх.

Өнөөдөр болохоороо агаарын хөлгийн түлшний талаар бүгдээрээ ярьж байна. 22 онд 38 мянга гаруй тонныг авдаг байсан бол 25 онд 84 болсон гэхээр даруй 2 дахин аль хэдийн өсчихсөн. Цаашаагаа ингээд өсөх нь. Жуулчдын тоо бас 2.5 саяд хүрнэ гэсэн тоонд танай энэ танилцуулга дээр танилцуулагдаад. Хамгийн гол нь нислэгийн тийзийн үнэ 36 хувь нь агаарын хөлгийнхөө түлшнээсээ хамаарч байдаг гэсэн мэдээллийг нийт сонсож байгаа бүх иргэд маань ойлгож аваасай гэдгийг харуулж байгаа юм. Дурдъя гэж бодлоо.

Тэгэхээр агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахын тулд л энэ хэлэлцээрийг хийж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд яг энэ хэлэлцээрийг бид бид нар дэмжээд л явах байх. Дэмжих нь ч зүйтэй байх. Тэгэхдээ яг дараагийн арга хэмжээнүүд нь юу байх юм? Хэзээ тэр дэд бүтцээ, цэнэглэх дэд бүтцээ бий болгох юм? Тэгээд хамтарсан компани бас байгуулж байгаа тээ? Тэгэхээр тэр хамтарсан компанийнх нь үйл ажиллагаа нь яг яаж явах юм? Тэгээд яг цааш цаашдаа авч хэрэгжүүлэх ажил нь хэдэн он гэхэд ер нь дэд бүтэц нь яг бий болоод бид нар ийм тогтвортой байдлаа бүрэн хангах юм бэ гэдэг дээр хариулт авъя.

Хоёр дахь асуудал нь болохоор энэ маргааныг Беларус улсын Минск хотод байрлах Беларусын Худалдаа аж үйлдвэрийн танхим тэгсэн мөртөө олон улсын арбитрын шүүхэд тус шүүхийн 2011 оны журмын дагуу хэлэлцүүлэхээр шилжүүлнэ. 2011 гэхээр чинь Соёлмаа дарга одоо бол 15 жилийн өмнөх журам байгаад байна шүү дээ. Энийг бүүр ингэж тухайлан зааж өгөх ёстой байсан уу? Одоо ингээд эцсийн зөвшилцсөн хувилбар нь орж ирлээ гээд түрүүн сайд танилцуулсан. Тэгэхээр бид нар эндээс санал гаргаад ч бас засагдахгүй нөхцөл байдалд орчихсон болов уу? Зүгээр яах вэ Минскийн арбитрын шүүх гэдгээр нь л орчих байсан биш үү? Ийм 2 асуудал

Р.Сэддорж: Индэр дээр. Хариулт индрийн микрофон. Өөрийгөө танилцуулаад.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Уянгаа гишүүний асуусан асуултад хариулъя.

Одоогоор энэ гэрээний үндсэн үүх түүх нь 2018 онд Монгол Улсад шинэ нисэх онгоцны буудал баригдаж байх үед тухайн үеийн Алс Дорнодын эдийн засгийн форумын үеэр Монгол Улсын агаарын шатахуун хангамжийг Оросын Холбооны Улс хариуцаж хамтарч ажиллала гэдэг саналыг тавиад тухайн үеийн сайд нар санамж бичиг байгуулсан юм байна лээ. Энэ хүрээндээ ингээд үргэлжлээд явж байгаа ажил.

2022 оны 3 сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ёндон сайдыг байх үед хамтарсан компанийг ямархуу байдлаар байгуулах вэ гэдэг санамж бичгийг байгуулсан байдаг. Тухайлбал, Монгол Улс 60 хувийг эзэмшинэ, 40 хувийг Оросын тал эзэмшинэ. Хамтарсан компани шинэ нисэх дээр ямар үйл ажиллагаа явуулах вэ гэвэл шинэ нисэхийн шатахуун хангамжийн байгууламжийг түрээсэлнэ. Түрээслээд шатахууны, онгоцны сумалгааг хийх л тийм үндсэн юутай. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт гэдэг дээр бол дундын шинэ нисэх маань төмөр замтай ямар

нэгэн холболт байхгүй. Дундын хадгалах сав ч гэдэг юм уу, дундын оффис гэдэг тиймэрхүү дэд бүтцийн асуудлууд яригдана. Яг шинэ нисэх онгоцны буудал дээр шинээр ямар нэгэн байгууламж барина, хөрөнгө оруулна гэсэн ойлголт байхгүй. Одоогоор яригддаг байх. Түрээсэлж ажиллуулна шинэ нисэх онгоцны буудлыг.

Р.Сэддорж: Гадаад хэргийн яам үргэлжлүүлж хариулна.

Ж.Соёлмаа: Уянгаа гишүүний асуултад хариулъя. Түрүүн танилцуулга дээр дурдагдсанаар болохоор анхдагч төсөл дээр Оросын Холбооны Улсын Арбитрын шүүхээр шийдвэрлэхээр байсан. Түүний дагуу Монголын талаас санал гаргаад дундын шүүхийг сонгоё гэсэн ийм саналыг гаргасан.

Оросын талаас энэ дээр дээр эсэргүүцсэн байр суурийг удаа дараа илэрхийлсэн. Тэгээд удаа дараагийн хэлэлцээний үр дүнд манай тал Казахстаны шүүх гэж бас санал болгож үзсэн. Тэгээд айлын тал ямар ч байсан Оросын шүүхээ больё тэгэхдээ дундын шүүх дээр Беларусыг сонгоё гэсэн ийм саналыг хэлэлцээний явцад илэрхийлсэн юм. Тухайн саналыг бид нар судалж үзэхэд олон улсын Беларус Улсын Минск хотод байрлах Беларусын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитрын шүүхэд тус шүүхийн журмын дагуу хэлэлцүүлэхээр шилжүүлнэ гэсэн ийм үндсэн зохицуулалт оруулсан. Шүүхийн тухайн шүүхийн хувьд гэх юм бол Юнитералын эрх зүйн зарчмаар маргааныг шийдвэрлэдэг. Тухайлбал, өөрөөр хэлбэл энэ нь олон улсын жишигт нийцсэн ийм шүүх юм байна гэдэг ийм өнцгөөс бид нар энэ саналыг дэмжсэн. Энэ нөгөө тус.../минут дуусав./

Р.Сэддорж: Уянгаа гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: 2011 он гээд яг энэ журмынх нь хамгийн сүүлд батлагдсан оныг нь дурдаж өгөх шаардлагатай байсан уу гэдгийг л тодруулсан юм дарга. Хэрвээ солигдчих юм бол яах билээ? Сайжрах л байлгүй дээ.

Р.Сэддорж: Индрийн микрофон. Гадаад хэргийн яам.

Ж.Соёлмаа: Гол нь энэ зүйл нь болохоор аль шүүхийн сонголтын асуудлыг зохицуулсан байсан. Тэгээд одоо энэ шүүхийн хувьд гэх юм бол 11 оны журам нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа болохоор ингэж зохицуулахаас өөр аргагүй байсан. Дараагийн удаа жишээлбэл тухайн шүүхтэй холбоотой журам нь өөрчлөгдсөн тохиолдолд гол шүүхийн сонголт гэдэг нь гол point болно. Журмынх нь огноо өөрчлөгдсөн энэ дээр шүүхийн өөрчлөлт дээр нөлөөлөхгүй гэсэн үг.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Энэ 2022 онд яг энэ Их Хурлаар орж ирж байсныг би их тод санаад байгаа. Яагаад гэхээр тухайн үед энэ “Улаан бал” гэдэг нэвтрүүлэг хийдэг. Түрүүгээрээ энийг ярьж байсан юм. Ганцхан энэ шатахуунтай холбоотой, шатахуунаа тогтвортой нийлүүлэлттэй холбоотой асуудал биш байна. Олон улсын харилцаа, геополитикийн асуудал байна, манай тусгаар тогтнолтой холбоотой асуудал байна гээд ингэж болохгүй гэдэг утгатай бас энэ нэвтрүүлэг хийж байсан юм. Тэгээд өмнө нь бас чуулганаар энэ Их Хурлыг байх үед бас энэ хэлэлцээр орж ирэхэд бид нар бас энэ саналаа хэлээд манай Байнгын хороо дэмжээгүйгээр гаргаж байсан юм. Тэгээд яах вэ миний ойлгоод

байгаагаар энэ манай агаарын хөлгийн шатахууны хэрэгцээ нэмэгдээд байгаа. Нийлүүлэгч тал нь асуудал үүсээд байгаа.

Тийм учраас тогтвортойгоор шатахуунтай байхын тулд тодорхой хэлэлцээр хийж бүүр буулт хийж байгаа л гэж би ойлгоод байна. Тэгээд энэ дээр жишээлбэл сая хассан гэж хэлж байгаа 7 дугаар зүйл дээр тодорхой хуулийн өөрчлөлт байх юм бол энэ нь бараг хэрэгсэхгүй, хүлээн зөвшөөрөхгүй, хэрэгжүүлэхгүй байж болохоор иймэрхүү буултууд энэ тэр хийчихсэн. Тэгээд сая засварыг би ойлголоо.

7 дугаар зүйлийн 2 дугаар доголыг аваад хаячихсан юм байна. Тэгсэн чинь бүүр байснаасаа дордчихож байгаа юм биш үү? 7 дугаар зүйлийн 1 дүгээр догол дээр болохоор нийлүүлэлттэй холбоотой нөхцөл байдлыг доройтоход хүргэсэн гэж, доройтоход хүргэсэн гэдгээ хэлээд 2 дугаар доголоор доройтоход хүргэнэ гэж юугаа хэлээд байгаа юм бэ гэдгийг 2 дугаар доголоор тайлбарласан. Энэ дээр хуулийн өөрчлөлтүүд болон бусад юмнууд гээд ингээд тодорхой заачихсан байсныг нь энэ доголыг хасчихаар одоо сүүлдээ юуг доройтсон гэж үзэх юм бэ? Батнайрамдалаа, Батсүмбэрэл байж бай даа. Тэгээд юу доройтсон гэж үзэх юм бэ гэдгээ тодорхойгүй орхичхож байгаа юм.

Тэгэнгүүт юуг л юуг нөхцөл байдлыг доройтууллаа гээд аваад үзчих юм биш үү? Ийм нөхцөл байдал. Ер нь бид нар ингээд нэг талдаа нефть боловсруулах үйлдвэр байгуулаад энэ шатахууны хувьд бид нар бас хараат байдлаасаа гаръя гээд ингээд яваад байдаг. Нөгөө талдаа байнга авдаг 100 хувь нийлүүлдэг газартайгаа тогтвортой ингээд 20, 15 жилийн хэлэлцээр байгуулаад ерөөсөө эндээсээ л аваад явъя гээд байдаг. Энэ хэлэлцээр биш ийм тулгалтууд л ингээд тогтмол яваад байдаг ийм нөхцөл байгаа. Мэдээжийн хэрэг бид нар байгаа нөхцөлөө ойлголгүй яах вэ. Гэхдээ арай л дэндүү өндөр үнээр, өндөр төлбөрөөр бид нар ийм шатахуунтай байх ийм хэлэлцээр хийгээд байгаа юм биш үү дээ гэдэг л ийм байр суурийг байнга илэрхийлээд байгаа юм. Энэ дээр.

Р.Сэддорж: Дамдинням сайд.

Г.Дамдинням: Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя. Бас тийм болгоомжлол байгааг үгүйсгэхгүй. Би ч бас өөрөө энэ асуудал дээр нэлээн энэ ер нь Их Хурлаар орж ирэхэд, өнгөрсөн хавар орж ирэхэд бол орчуулгын алдаа ч байсан байх нийт Байнгын хороодоор яригдсан 6 асуудал байдаг юм. 6 асуудлын өнгөрсөн хугацаанд сайдын ажлыг аваад үндсэндээ 6, бараг 7-н ч удаа уулзав уу даа Оросуудтай. 8-н ч удаа уулзсан юм уу онлайнаа оруулаад. Ярилцсаар байгаад үндсэндээ 6 асуудлын 5-ыг нь Монголын талын саналаар 100 хувь томьёолуулж чадсан. Сайжруулсан гэсэн үг.

Хоёрдугаар асуудал бол Лодойсамбуу гишүүнээ энэ хэлэлцээр манай дотоодын газрын тосны үйлдвэрийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажил дуусаад бүтээгдэхүүн гарахад тэндээсээ шууд авах бүрэн эрхтэй. Бид нар зөвхөн Оросоос авах албагүй. Энэ хэлэлцээрийн үр дүн тийм юм. Зах зээлийн үнээрээ хямд үнээр авах бүрэн эрхтэй манайх. Энэ хэлэлцээрээр бид нар зөвхөн Оросоос авна гэсэн хязгаарлалт байхгүй. Хэрэвзээ Сингапурын бирж дээр хямдхан байвал Сингапураас авч болно. Хятадаас авч болно. Тэгэхээр энд бол, хэлэлцээр дээр бид нар нэлээн бас тийм өөрсдийнхөө талын байр суурийг нэлээн хатуу хамгаалж авч гарч чадсан. Ийм л үр дүн байгаа л даа.

7 дугаар зүйлтэй холбоотой асуудлыг Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүйн газрынхан хариулсан нь зөв байх. Юу вэ? Манай Хишигдалай хариулчих. Ер нь ийм юм байгаа юм олон улсын хуучин бол яг одоо тулгачихсан ч юм шиг. Бүүр ийм бүх юмнуудаа заагаад хатуу хөдлөхгүй шүү гээд оруулаад ирчихсэн байсан. Одоо бол бид нар олон улсын гэрээ, хэлцлийн зарчмаар явъя гэдэг өөрчлөлтийг л оруулсан гэж ойлгохоор байгаа. Тэгж одоо ойлгож байгаа. Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүйн газрынхнаар хянуулсан. Манай Хишигдалай дарга бас үргэлжлүүлээд хариулчих.

Р.Сэддорж: Индрийн микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. 7 дугаар зүйл ерөнхий бүхэлдээ Монгол Улсын хууль тогтоомжид гэрээ зурсан өдрөөс хойш өөрчлөлт орсон тохиолдолд эрх зүйн байдлыг дордуулсан гэж үзээд энэ өөрчлөлтүүд дордуулсан зүйл заалт үйлчлэхгүй гэсэн утгатай. 2 дахь догол мөр бол энийгээ бүр тодруулж өгөөд тодорхойгүй хөнгөлөлт, давуу эрхийг цуцлах нь гэдэг ямар нэгэн байдлаар компанид бид нар давуу эрх юм, зүйл энэ дээр байхгүй. Цорын ганц объектын асуудлыг хамтарч эзэмших л зохицуулалт байгаа. Дэндүү нарийсгасан ийм зүйл, заалт, тодорхойгүй зүйл, заалтууд байсан учраас энийг хасаад зүгээр ерөнхий олон улсын гэрээнд байдаг энэ Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт орвол гэрээ зурсан өдрөөс хойш өмнө нь мөрдөгдөж байсан хууль тогтоомжийг дагаж мөрдөнө өө гэдэг ерөнхий байдлаар л .../минут дуусав./

Р.Сэддорж: Лодойсамбуу гишүүн тодруулж асууя.

Ч.Лодойсамбуу: Тийм. Яг ингээд тодорхой нарийсгаад заачихсан байсныг нь ерөнхий болгочихоор юуг ч нөхцөл байдлыг доройтоход хүргэсэн гээд үзчих боломж нь үүсчихсэн байна л гэж. Ингээд уншихад тэгж харагдаж байгаа.

Сая Дамдинням сайд хэлж байна. Энэ дараа нь үүсэх үр дагаврууд манай энэ хэлэлцээрийн дараа манайх бас ингээд өөрсдийн үйлдвэрээсээ авах ийм боломжууд нь бий болно гэж. Ер нь энэ зах зээл дээр ямар нөлөөлөл үзүүлэх вэ? Эрсдэлийг хэр хэн тооцсон бэ? Жишээлбэл манай энэ агаарын тээвэрт оролцогч компаниуд олон улсын компаниуд дээр жишээлбэл энэ Орос, Монголын хамтарсан компани байгуулаад шатахуунаа нийлүүлэх гэж байна шүү дээ. Тэгээд энэ дээр жишээлбэл ялгамжтай байдал үүсгээд гаднын бусад авиа компаниудыг шахан холдуулах ийм бодлого яваад байх эрсдэл бий болно. Энийг хэрхэн тооцож энэ хэлэлцээр дээр оруулсан? Би бол харсангүй байгаа вэ гэдэг юм. Энэ зөвхөн нөгөө онгоцондоо бензинтэй байх тухай биш олон улсын харилцаагаа цаашдаа энэ хэрхэн авч явах вэ, олон талт хамтын ажиллагаагаа яаж авч явах вэ.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт Индрийн микрофон Уул уурхайн яам.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Энэ дээр өмнөх Байнгын хорооны хуралдаан дээр бас асуугдаж байсан асуулт. Монгол Улс, Оросын Холбооны Улс бусад улсын онгоцыг цэнэглэхгүй гэвэл яах вэ гэж жишээ нь асуулт ирж байсан. Энэ дээр Олон улсын нисэхийн Чикагогийн конвенц гэж байдаг. Энэ Олон улсын иргэний нисэхийн үндсэн хууль байдаг. 15 дугаар зүйл дээр нисэхийн буудлын үйлчилгээ авах хураамж нь бүх улсын агаарын хөлгүүдэд ижил, ялгаварлан гадуурхахгүй байх

ёстой гэсэн заалт. Агаарын хөлгийн бак-д байгаа шатахууныг татвараас чөлөөлөх тухай гэж бас заалтууд байдаг. Икиао гэж байдаг. Татварын бодлогын баримт бичиг гээд. Энэ дээр бас татварт ноогдуулахгүй байх олон улсын харилцаанд ижил нөхцөлөөр хангах үндсэн зарч орчмыг нисэх буудал хангана гэсэн заалтууд байдаг.

Бусад шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүд бас өнөөдөр нисэх онгоцны буудал дээр шатахуун хангамжийг сумлах үйлчилгээг бас үзүүлээд явж байгаа. Шинэ нисэх онгоцны буудлын цэнэглэх байгууламжийг.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя.

Ч.Хишигдалай: Үнэлгээ өндөр байна гэдэг утгаар шууд цэнэглэх байгууламжаар биш автомашинаар цэнэглэх үйлчилгээ үзүүлээд явж байгаа гэх мэтчилэн шинэ нисэх онгоцны буудал дээр ямар нэгэн шатахуун импортлогч компани үйл ажиллагаа явуулах боломж нь нээлттэй байгаа.

Хоёр дахь асуудал нь энэ 22 онд Ёндон сайдын байгуулсан санамж бичиг байгаа. Үүн дээр бас Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулагдвал яах вэ? Бүтээгдэхүүнийг 100 хувь үйлдвэрээс худалдаж авна. Илүү гарсан хэрэгцээг Оросын Холбооны Улс нийлүүлнэ. Оросын Холбооны Улсаас нийт худалдан авч байгаа бүтээгдэхүүн үйлдвэрээс гадна үйлдвэрийг ашиглалтад орох хугацаанд 80 хүртэлх хувийг Оросын Холбооны Улс нийлүүлнэ. 20 хүртэл хувийг бусад улсаас худалдаж авч нийлүүлж болно гэж гэх мэтчилэн ийм нарийвчилсан заалтууд нь яг байгаа. Дээр нь энэ хэлэлцээр батлагдсаны дараа хамтарсан компани байгуулах асуудал яригдана. Хоёр талаас итгэмжлэгдсэн байгууллага болох “Роснефть Аэро”.../минут дуусав./

Р.Сэддорж: Лодойсамбуу гишүүн нэмэлт тодруулга.

Ч.Лодойсамбуу: Тэгэхээр энэ яах вэ тарифын асуудал үүсээд хамтарсан компани чинь тарифаараа янз янзын бодлого хэрэгжүүлээд байх вий дээ гэдэг дээр эрсдэл байх уу? Тэр дээрээ нарийн хэлэлцээртээ тусгаж өгсөн юм уу гэдгийг л асуусан юм.

Хоёрдугаарт, би нэг юм дутуу орхисон байна. Түрүүн энэ арбитртай холбоотой арбитр ингээд 2 улс хамтраад 1 компани байгуулаад маргаан үүсэх юм бол гуравдагч этгээдээр илүү маргаанаа шийдүүлье л гэж байгаа шүү дээ. Үндсэн санаа нь Арбитр гэхээрээ. Тэгэнгүүт бид нар санал тавьсан юм байна Оросынх биш ээ гээд. Тэгэнгүүт Беларус болгосон юм байна. Ялгаа байна уу? Одоо бид нар энэ дээрээ хатуу байж болохгүй байсан уу хэлэлцээр хийгч тал нь манайх?

Р.Сэддорж: Хариулт Гадаад хэргийн яам.

Ж.Соёлмаа: Асуултад хариулъя. Түрүүн тайлбарласнаар болохоор анх Оросын тал анх 9 сарын 3-нд гарын үсэг зурсан хэлэлцээр дээр болохоор Москвагийн арбитр байсан. Тэр дээр Байнгын хороон дээр бид нар асуудлыг танилцуулахад нэлээн шүүмжлэлтэй. Түүний дагуу бид нар Оросын талд удаа дараагийн хэлэлцээрээр гуравдагч улсын арбитр байя гэсэн ийм саналуудаа тавьсан. Тэгээд Москвагийн арбитрыг хүлээн зөвшөөрөхгүй байх тэр буулт хийгээд дараагийн ээлжид Казахстаны талын Казахстаны арбитраар гэж ярьсан. Тэгээд

гуравдагч арбитр гэж нэгэнт санал дээр нийцсэн учраас Беларус гэж сонгосон байгаа.

Ж.Соёлмаа: Гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Лодойсамбуу гишүүнээр, Энхцэцэг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу.

Ч.Лодойсамбуу: Тэгээд яах вэ бид нарыг анх парламентад тангараг өргөсний дараа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, тагнуул энэ тэрээс мэдээлэл хийсэн л дээ. Манай Их Хурлын гишүүд бас ингээд гадаад улс, хөрш орнуудтай холбоотой асуудал дээр болгоомжтой байр сууриа илэрхийлээрэй энэ тэр гээд. Тэрийг бол хүндэтгэж байгаа. Тийм бас мэдээлэл бид нарт ер нь жил болгон л өгдөг.

Гэхдээ бид нар хар энэ мөнхөд ийм зөвхөн түлштэй болохын тулд, эс үгүй бол тогтой болохын тулд, тогтой байхын тулд ийм буулт хийдэг. Тэгээд тэрийгээ яг л ийм байх ёстой юм шигээр хүлээн зөвшөөрч ярьдаг. Бид нар жижигхэн ард түмэн шүү дээ. Бид нар жижигхэн, наадуул чинь том, бид нарыг залгичихна, харж байгаа биз, залгиж байгаа биз гээд л ингээд ярьдаг. Тэгээд ингээд хэлэлцээрүүд гээд ороод ирэхээр хэлэлцээр биш дандаа ийм тулгалтууд байдаг. Өмнө бас бид нар Евроазийн эдийн засгийн холбоотой хамтын энэ хэлэлцээр хийсэн асуудлууд дээр бас энийг хэлж л байсан. Одоо бид нар ингэж байна шүү дээ. Энийг зүгээр энгийнээр хэлэх юм бол дэлгүүрээс талх авдаг байя гэж бодъё л доо.

Тэгсэн нөгөө дэлгүүр нь та ер нь манай талханд дуртай юм байна, манай талхыг л ер нь авдаг юм чинь танай гал тогоонд ер нь ороод хийж байя. Тэгээд та байнга талхтай. Бид нар дараа нь өөр газраас талх авах, эс үгүй бол тэр газрын талхны чанар муудах, сонголт байхгүй, өрсөлдөөн байхгүй. Энийг больчихъё гэхээр үгүй тэгээд наадуул чинь бид нарыг талхыг маань тасалчихна шүү дээ тэгээд хоолгүй боллоо яах вэ та нар өөрсдөө талхаа хийж чаддаггүй юм чинь. Нэг бол ингээд улс болж тоглоод байгаа юм шиг, нэг бол үнэхээр бодит байдалтай яг яах вэ хэлэлцээр хийж байгаа хүмүүсийг би аягүй сайн ойлгож байгаа. Энэ дээр өчнөөн олон жил яг нүүр тулаад хэлэлцээд явдаг хүмүүс асар хүнд нөхцөлтэй л ажиллаж байгаа. Тэрийг би ойлгож байна.

Гэхдээ энэ бол парламентын засаглалтай улс. Парламентын гишүүд нь олон нийтээс ард түмнээсээ санал аваад гараад ирдэг. Тэгэхээрээ тэднийхээ дуу хоолой, улсынхаа тусгаар тогтнолын талд бас дуугарч байх хэрэгтэй. Хэлж байх, санаа зовж байх хэрэгтэй. Тийм учраас Засгийн газар ямар ч хэлэлцээр хийгээд, ямар ч буулт хийгээд ирсэн бай Монгол Улсын Их Хурал нь энэ дээр шийдвэр гаргаад, зоригтой гаргаад явдаг байх хэрэгтэй. Тэгээд л явдаг байсан.

2022 онд Занданшатар даргатай Их Хурал энэнд бас тодорхой хариултаа өгөөд л буцааж байсан. Одоо бас орж ирж байна. Монгол Улс парламентын засаглалтай улс. Өөрөөр хэлэх юм бол ард түмэн нь төрөө барьдаг улс. Тэгэхээрээ бас иймэрхүү тусгаар тогтнолтой холбоотой, бие даасан улс байхтай холбоотой иймэрхүү асуудлууд дээр бас Монгол Улсын Их Хурлын гишүүд маань бас ухаантай шийдвэр гаргана байх гэж бодож хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг.

М.Энхцэцэг: Энэ гэрээ, хэлэлцээрт орж байгаа өөрчлөлтийн хувьд зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд мэдээж агаарын тээврийн шатахууны асуудал гэдэг бол Монгол Улсын хувьд амин чухал асуудал. Мэдээж энийг бид нар одоогийн байдлаар дотоодын компаниуд хангаад явж байгаа.

Тэгэхээр энэ хэлэлцээрийн хүрээнд хамтарсан компани байгуулаад энэ шатахууны асуудлыг ингээд шийдвэрлэх цоо шинэ ийм механизм боловсруулж орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэний гол үндсэн зорилго мэдээж гол чухал юм бол мэдээж тэр онгоцны тийзийн үнэ. Бид нар Монгол Улс руу ингээд маш олон хүмүүс аялах сонирхолтой байна, хүсэлтэй байна гэдэг. Тэгээд хамгийн гайхалтай юм нь танай улсын онгоцны билет маш үнэтэй байдаг гэдэг. Тэгэхээр онгоцны билетийн гол үнэтэй байлгаж байгаа бас нэг үзүүлэлт мэдээж олон үзүүлэлт байгаа. Нэг том үзүүлэлт мэдээж нөгөө шатахууны өртгийн асуудал.

Тэгэхээр шатахууныг одоогийн байдлаар дотоодын хэдэн монопол компани хангаж байгаа учраас асар өндөр үнэтэй байна. Тэрнээс болоод билетийн үнэ өндөр байна гэдэг асуудлыг олон жил хүмүүс их ярьдаг гэж ойлгодог. Тэгэхээр энэ хэлэлцээрийн үр дүнд хамгийн гол нь бид нар юу хүлээж байгаа вэ гээд тэгэхээр шатахуун тэр онгоцны билетийн үнэ буурах ёстой. Тэгж байж олон зүй жуулчид Монгол руу ирэх тэр боломжийг нээх ёстой. Мэдээж тэр үндэсний аюулгүй байдлын асуудал асар чухал асуудал.

Тэгэхдээ л бид нар гол үндсэн шатахуунаа авч байгаа ганц суваг маань л энэ. Тэгэхээр энэ зорилгодоо хүрсэн ийм хэлэлцээрийг улам сайжруулах зорилгоор энэ өөрчлөлтүүд орж ирж байна гэж ингэж харж байна. Тэгэхээр зарчмын хувьд энэ асуудлыг дэмжиж байна. Тэгээд хамгийн гол нь тэр нь бид нар нөгөө хүсээд байгаа үр дүндээ хүрээрэй. Тэр онгоцны билетийн үнийг тодорхой хувиар бууруулсан тийм үр дүнд заавал хүрэх ёстой шүү гэж ингэж хэлмээр байна.

Р.Сэддорж: Өнөөдөр энэ асуудал онцгой бас чухал үед орж ирж байна. Бас нэлээн хугацаагаар хойшилчхоод орж ирж байгаа. Тэгэхээр дэлхийн өнөөгийн нөхцөл байдал энэ түлш шатахууны хомсдолтой нүүр тулах ийм үед орж ирж байна. Тэгээд чухал хэлэлцээр гэж үзэж байна. Манай улс хоёр агаарын хилтэй. Тэгэхээр нэг агаарын хил. Хилтэйгээ, хилийн оронтойгоо хамтран ажиллах тухай асуудал байгаа. Дээрээс нь сая гишүүдийн хэлж байгаа зүйлүүдийг цаашдаа энэ протоколд тэмдэглэж 2 яам Засгийн газар анхаарч ажиллах юм байна гарын үсэг зуртал.

Тэгэхээр энэ хамгийн гол зүйл бол агаарын тээврийн билетийн үнэ, зорчигчдын билетийн үнэ, дээрээс нь энэ бусад энэнтэй холбоотой бусад түлш, шатахууны аюулгүй байдал, ханган нийлүүлэлтийн аюулгүй байдалд энэ эергээр нөлөөлнө өө гэж гишүүдийн олонх нь бас ойлгож байгаа байх. Болгоомжлох юмнуудыг бас гишүүд сая хэллээ.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт явуулъя.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд гишүүн байна уу? Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

13.38 цаг

Хэлэлцэх асуудал 2.Монгол Улс Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-4” төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Жавхлан танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Б.Жавхлан: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Эрчим хүч-4” төсөл буюу Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220квт-ын 2 хэлхээт 287км урт цахилгаан дамжуулан агаарын шугам, дэд станцыг өргөтгөх төсөл нь Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд Засгийн газраас тус төслийг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэхээр зээлийн хэлэлцээрийг хийгээд байна.

Энэхүү төслийг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкнаас олгох 78 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд зээлийн хугацаа 25 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил бөгөөд баталгаат ... санхүүжилтийн хүү SOFR дээр нэмэх нь 1.4 хувийн нэмэгдэлтэй хувьсах хүүтэй байна. Тус зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ бөгөөд Өрийн удирдлагын тухай хуулийн 24.3-д заасны дагуу зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн болно.

Төслийн хүрээнд шинээр Мандалговь 12 чиглэлийн 287км урттай 220квт-ын цахилаан дамжуулах агаарын шугам болон Өвөрхангай дэд станцыг шинээр барих Баянхонгор, Арвайхээр, Мандалговь дэд станцыг өргөтгөх ажлууд хийгдэх бөгөөд төслийг хэрэгжүүлснээр бүс нутгийн 50 мянга гаруй хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж, хангайн болон баруун бүсийн аймгуудад төлөвлөж буй хөгжлийн хөтөлбөрүүдийг эрчим хүчний хангамжаар бүрэн хангах боломж бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Иймд Монгол Улс Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4” төслийн зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Бат-Эрдэнийн Хулан Сангийн дэд сайд, Солонгын Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Эрчим хүчний яамнаас Сугаржавын Далхаасүрэн Эрчим хүчний дэд сайд, Огнонгийн Хуягцогт Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ичинхорлоогийн Лувсанцэрэн Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Билэгтийн Дашдаваа “Цахилгаан дамжуулан үндэсний сүлжээ” ТӨК-ийн гүйцэтгэх захирал, Батцэнгэлийн Лхагвадэмбэрэл “Цахилгаан дамжуулан үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Судалгаа, хөгжүүлэлт, төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаагаар тасаллаа. Мандхайгаар тасалж байна. Заяабал гишүүнээр тасалж байна. Ирцийн дарааллаар Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Энэ Мандалговь, Өвөрхангай дамжуулах шугам барьж байгаа. Энэ дээр зүгээр ер нь Мандалговьд юм уу, Өвөрхангайд нөгөө шинээр дулааны цахилгаан станц баригдахгүй юм уу тээ ер нь? Эхний ээлжид цахилгаан дамжуулах шугам сүлжээгээ өргөтгөх нь чухал байгаа юу? Яагаад гэхээр асууж байна гэхээр 287км урттай тэгээд ерөнхийдөө энэ чинь нэлээн урт хэмжээний тийм дамжуулах шугам сүлжээ барьж байгаа учраас шугамын алдагдал гээд зөндөө л асуудал үүснэ. Зүгээр ер нь төлөвлөж байгаа тийм цахилгаан дамжуулах дулааны цахилгаан станц барих тийм юу байхгүй байгаа юм уу л гэж асуух гэсэн юм.

Р.Сэддорж: Хариулт. Индрийн микрофон. Индрийн микрофон дээр өөрийгөө танилцуулаарай.

И.Лувсанцэрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Лувсанцэрэн. цахилгаан дамжуулах агаарын шугамыг 2022 оноос хойш зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлэхээр хөөцөлдсөн. Энэ төсөл маань эхний ээлжид хэрэгжсэнээр 2 талын эх үүсвэртэй болохоор төлөвлөгдсөн. Одоо байгаа шугамаар Булган дэд станцаас 400 гаруй километр цахилгаан дамжуулах агаарын шугамын 110 киловольтын цахилгаан дамжуулах агаараар очиж байгаа Арвайхээр дээр. Үүнийг 2 талын тэжээлийн эх үүсвэртэй болгож, цахилгаан эрчим хүчний найдвартай чанар хүртээмжийг дээшлүүлэх, бүс нутгийн цахилгаан хангамжийг сайжруулах ийм бодлого хэрэгжээд явж байгаа.

Үндсэндээ зээлийн хэлэлцээр батлагдсаны дараа 2 жилийн хугацаанд зохион байгуулаад ашиглалтад оруулах ийм ач холбогдолтой төсөл. Мэдээж нүүрс дээр суурилсан дулаан цахилгаан станцуудыг Эрчим хүчний яамнаас бодлогын түвшинд дэмжээд явж байгаа. Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэсэн хувийн хэвшлүүд дулаан цахилгаан станц барих сонирхлоо илэрхийлдэг. Гэвч одоогоор баригдсан төсөл харахан байхгүй байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль болон төсөл сонгон шалгаруулалтаар төвийн бүс дээр ялангуяа Мандалговь дэд станц дээр салхин цахилгаан станцын

100мвт-ын төслийг ойрын хугацаанд олон улсын нээлттэй өрсөлдөөн сонгон шалгаруулалтаар зохион байгуулахаар ажиллаж байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Уянга.

Р.Сэддорж: Сангийн сайд байгаа учраас бас нэг зүйлийг тодруулъя аа. Одоо бид нарын авах гэж байгаа энэ зээлийн хэлэлцээр болохоороо 78 сая ам доллар. Саяхан Чойжоо сайдын өгсөн ярилцлагаас хэдэн тоонуудыг тэмдэглэж авч байсан юм. Яг энэ эрчим хүчний салбар богино хугацаат өр төлбөр нь 629 тэрбум төгрөг. Тэр нь би ойлгохдоо энэ дулаан цахилгаан станцуудад өртөгтөө хүрэхгүйгээр хямд үнээр борлуулаад байдаг тэрэнтэй холбоотой богино хугацааны өр төлбөр юм болов уу гэж ойлгосон.

Урт хугацаандаа эргэн төлөх ёстой 2.1 их наяд төгрөгийн өр төлбөртэй. Тэгээд Эрдэнэбүрэн гээд бусад хүлээгдэж байгаа станцууд орох юм бол бүүр өр төлбөр нь 3 их наядаар нэмэгдээд 5 их наяд болно гэсэн тайлбарыг өгсөн байна лээ. Тэгэхээр одоо ингээд 78 сая ам.долларын зээл авлаа. Энэ зээлийн тааз, ер нь эрчим хүчний салбар хамгийн их ийм урт хугацааны өр төлбөртэй байдаг юм уу? Энэ ер нь зээлийн тааз эд нартай асуудалгүй юу? Тэгээд би зүгээр өөрийнхөө эргэн тойронд хамгийн хурднаараа мэдээлэл авах эх сурвалжийн Энхцэцэг гишүүн байлаа. Европын Сэргээн босгох хөгжлийн банкнаас энэ зээлийг их удаан хөөцөлдөж авч байгаа гэж ойлгосон. Тэгэхээр энд энэ зээлийн ерөнхий шаардлага ер нь бид нар өөрсдийнхөө төсөв дээр мэдээж даахгүй болохгүй болохоороо л ингэж зээл авч байгаа байх. Тэгэхээр энэ дээр тийм эрчим хүчний салбарын нийт дүр зургаар нь харвал өр төлбөртэй байна, яах ёстой юм бэ гэдэг шийдэл нь хэрвээ засгийн хэмжээнд яригдсан бол тэр дээр нь мэдээлэл авъя.

Р.Сэддорж: Сангийн сайд.

Б.Жавхлан: Эрчим хүчний салбарын өр зээлтэй холбоотой асуудлыг яамнаас нь хариулах нь зөв байх. Өрийн таазтай холбоотой асуудал энэ дээр нь би хариулъя. Монгол Улсын өрийн тааз хуулиараа 55 хувь хязгаар нь. Гүйцэтгэл 40 хувь. 15 их наядын бидэнд ийм нөөц байгаа гэсэн үг. 15 их наяд гэдэг маань 3.5 тэрбум доллар нэмж бид нар зээл авахад тааз хөндөгдөхгүй гэсэн үг. Тиймээс 3.5 тэрбум долларын нөөцөөс энэ 78 сая доллар гэдэг маань нөөцийнхөө хэдэн хувь бэ? 2 хувь л гэсэн үг. 100 хувь гэж үзэх юм бол 2 хувь дээр нь ашиглаж байна л гэсэн үг нөөцийнхөө, илүүдэл нөөцийнхөө гэсэн үг. Тэгэхээр тааз дээр санаа зовох зүйл байхгүй.

Ер нь эрчим хүчний салбар өөрөө төсөв дээрээс хөрөнгө оруулалт хийхэд маш хэтэрхий их ийм том төслүүд байдаг. Тийм учраас аль болох ийм хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, цаашдаа хэрвээ үнэхээр бид тарифаа бүрэн чөлөөлөөд энэ салбарын төслүүд маань өөрсдөө bankable болж чадах юм болбоос гаднын хөрөнгө оруулалтууд төр, хувийн хэвшлийн түншлэл, шууд хөрөнгө оруулалтууд гээд ийм эх үүсвэрүүд гадна талдаа яг ингээд л хүлээгээд л бэлэн байж байдаг. Энэ асуудлаа л одоо бид нар яаралтай шийдэх ёстой хамгийн тулгамдсан асуудал нь өөрөө энэ юм байгаа юм.

Урт хугацаат өр, урсгал өрүүд гээд салгаж ойлгох хэрэгтэй. Тэгэхээр саяын таны хэлдэг өрүүд нийт дүнгээр нь хэлж байна. Тэгэхээр тэр яг салбарын системийн урсгал өр болон нийт өр зээлүүдийн талаар Хуягцогт дарга хариулсан нь дээр байх. Дээрээс нь энэ зээл маань хар салбар биш яам биш энэ “Цахилгаан

дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчийн ХК энэ дамжуулан зээл болох юм. Тэгэхээр энэ төсөл нь, энэ төслийн зээлийн төлбөрийн эх үүсвэр нь бол энэ компани дээрээсээ тарифаараа үйлчилгээнийхээ төлбөрөөрөө цаашдаа хийгдээд явах ийм судалгаа хийгдсэн байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл төсөв дээр ямар нэгэн дарамт ирэхгүй байхаар ийм төлөвлөсөн гэсэн үг. Хуягцогт дарга.

Р.Сэддорж: Индрийн микрофон өөрийгөө танилцуулаад.

О.Хуягцогт: Уянга гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. Таны саяын тоонууд зөв. 2025 оны жилийн эцсээр эрчим хүчний салбарын ТӨК-удын богино хугацаат өр төлбөр бол 620.9 тэрбум төгрөгийн урьдчилсан гүйцэтгэлээр гарч байгаа. Энэ бол урсгал өр. Гол шалтгаан нь ер нь үнэ тарифыг 2019 оноос хойш өртгөөс доогуур яваад 2 удаа нэмэх оролдлого хийсэн. Гэвч энэ хэсэгчилж хэрэгжсэн. Ингээд Засгийн газрын 2025 оны 132, мөн 236 дугаар тогтоолуудаар энэ геополитик олон улсын энэ хямралтай нөхцөл байдалд үнэ тарифыг өсгөхгүй байх ийм чиглэлийг өгсөн. Эрчим хүчний салбарын ТӨК-уд тарифын орлогоороо энэ зохицуулалттай зах зээлээс санхүүжилтээ босгодог ийм онцлогтой. Энэ нь гэхдээ тарифын асуудлыг.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя индрийн микрофон.

О.Хуягцогт: Энэ амьжиргааны түвшин, эдийн засгийн нөхцөл, төсвийн нөхцөл байдалтай уялдуулан ингээд тарифыг ер нь өртөгт нь үе шаттай хүргэх чөлөөлөх ийм асуудлыг Эрчим хүчний яам Засгийн газрын түвшинд судалж зохицуулах хороотой танилцуулж байгаа. Энэ шийдэгдвэл энэ 2, 3 жилийн хугацаанд шийдэгдэнэ. Гэхдээ энэ хөрөнгө оруулалт бол урт хугацааны шийдлүүд байгаа.

Тэгэхээр одоо таван жилийн үндсэн чиглэлд туссан тодорхой шийдлүүд гараад хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд бол 27 орчим их наяд төгрөгийн их наяд төгрөгийн өртөгтэй ийм төслүүд төр, хувийн хэвшлийн түншлэл, бүх талын эх үүсвэрээр хэрэгжиж байна. Ингэж байж бид эрчим хүчний дутагдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ хангах, эдийн засгийн хөгжлийн сууриа тавих ийм шийдлүүдийг гаргах ёстой юм байгаа. Энийг хүлээгээд энийг хийгдэхгүй байх юм бол энэ хэмжээгээр энэ төлөвлөж байгаа хөгжлийн төлөвлөлтүүд хойшлох ийм эрсдэлтэй байгаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг асуулт асууна.

Р.Сэддорж: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Мандалговь-Арвайхээрийн 220 киловольтын 278км гээд маш урт шугамын ийм 287км ийм шугамыг одоо ингээд зээлийн хөрөнгөөр барихаар 78 сая доллароор барихаар ингээд орж ирж байна. Тэгээд миний нэг дүгээр асуулт болохоор энэ хөрөнгийг цахилгаан дамжуулах шугам барихад зарцуулж байгаа нь хэр оновчтой байсан бэ? Уул нь эх үүсвэр барих нь арай оновчтой байсан юм биш үү гэж асуумаар байна л даа нэгдүгээр асуулт.

Яагаад гэхээр та бүхэн мэдэж байгаа өнөөдөр Баянхонгор, Арвайхээр агаарын бохирдлын хувьд, дулаан хангамжийн хувьд, цахилгаан хангамжийн хувьд хамгийн бүүр аймшгийн үлгэр жишээ болсон ийм аймгуудын нэг болчихоод байна шүү дээ. Гэтэл энэ аймгууд дээр дулааны станцыг, 50мвт-ын дулааны станц

бариад тэр дулаан цахилгаан хангамжийн асуудлыг шийдэхэд энэ өр зээлийг зарцуулах нь зүйтэй байсан юм биш үү гэдэг энэ нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал болохоор мэдээж цахилгаан дамжуулах шугам гэдэг бол цахилгаан үйлдвэрлэгч орлого олохгүй. Цахилгаан дамжуулах сүлжээ тарифаараа нөхнө. Тэгэхээр одоо байгаа тариф чинь яг энэ өр зээлийг нөхөх бүрэн боломжтой юу? Эсвэл та бүхэн тооцооллоор хэд болгож одоо байгаа тарифыг чинь хэд болгож өсгөж байж энэ өрийг төлөх ийм тооцоолол хийсэн бэ гэдэг хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт болохоор ер нь бид нар хар ингээд өргөтгөл ч юм уу ийм ч юм ингээд тухайн компанийг даана гээд ингээд хийчихдэг. Жишээ нь дулааны цахилгаан станц IV-ийн хувьд та бүхэн мэдэж байгаа. Өргөтгөлийг Хөгжлийн банкны зээлээр хийсэн. Тэгээд дулааны цахилгаан станц IV-ийн тариф нь тэр өргөтгөлийн хөрөнгө оруулалтыг нөхөх боломжгүй. Тэгээд нөгөө өрнийх нь хүү нь ингээд нөгөө доллароор байсан өр нь төгрөг рүү шилжүүлсэн. Одоо бараг бизнесийн зээл биш, хөрөнгө оруулалтын зээл биш, бизнесийн зээлийн хэмжээний ийм өртөгтэй, тарифтай, хүүтэй зээл ингээд тасралтгүй өр нь нэмэгдээд байгаа юм.

Тэгсэн мөртөө тариф нь нөхөхгүй тэгээд тариф нь нөхөхгүй тохиолдолд тэрийг яах ёстой вэ гэхээр тэр өрийг улс л хаах ёстой шүү дээ. Тэр хөрөнгө оруулалтыг улс л хаах ёстой. Гэтэл хаахгүй ийм асуудал үүсээд явж байгаа. Тэгэхээр цахилгаан дамжуулах сүлжээн дээр дахиад ийм асуудал үүсэх юм биш үү гэдэг ийм асуулт байна. Энэ дээр хариулаад өгөөч.

Р.Сэддорж: Эрчим хүчний яам индрийн микрофон.

Б.Дашдаваа: Сайн байцаана уу? “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” компанийн гүйцэтгэх захирал Дашдаваа. Энэ бүс нутагт ерөнхийдөө 110 киловольтын 830км агаарын шугам манай компанийн үйлчлэх хүрээнд байгаа. Энэ бол маш их алслагдсан алдаг л өндөртэй эрчим хүчний чанар, стандарт хангагдахгүй ийм байгаа. Үндсэндээ 11 аймгийн 160 мянган хэрэглэгчийг хангаж байгаа ийм бүс нутаг байгаа. Өнөөдрийн байдлаар Баянхонгор энэ тийшээгээ 110 киловольтын хүчлийн түвшин 90 киловольттой үндсэндээ эрчим хүчний чанарын шаардлага хангахгүй байгаа. Энэ шугам баригдсанаар бид нар тооцоолол хийсэн. Эрчим хүчний тасалдал 50 хувиар буурна, эрчим хүчний алдагдал 42 хувиар буурна. Энэнээс жилд 4.5-4.7 тэрбум төгрөгийн хэмнэлт гарах юм байна.

Бусад техникийн нөхцөл олгогдохгүй хүлээгдэж байгаа уул уурхайн болон аж ахуйн нэгжүүд олон хэрэглэгчийн асуудал шийдэгдэнэ.

Ер нь энэ шугам дээр Эрдэнэт, Булганы шугам өнөөдрийн байдлаар 125-ийн ачаалалтай сүүлийн хэдэн жилийн өвлийг давж байгаа. Сүүлийн 10 жилд энэ 3 ч удаагийн том аваар гарсан. Хамгийн дээд тал нь 8 аймгийн 92 сумын хэрэглэгчид 4 өдөр ямар нэгэн гэрэл цахилгаангүй, тоггүй байсан ийм кэйсүүд байгаа. Тэгэхээр энд энэ шугам баригдсанаар эрчим хүчний чанар, стандартын шаардлага бүрэн хангагдана, шинэ хэрэглэгчид холбогдох боломж бий болно, эрчим хүчний тогтвортой найдвартай ажиллагаа дээшилнэ.

Мөн Хархорин сумыг улсын нийслэлтэй болгохтой холбоотойгоор Арвайхээрээс 220 киловольтын шугамаар Хархорин нийслэлийн бүтээн

байгуулалтууд явах ийм тооцоо байгаа. Эх үүсвэрүүд бол 2027 оноос өнөөдрийн үйлдвэрлэлийн хэрэглээгээ гүйцэх, тодорхой эх үүсвэрүүд орж байгаа. Яг энэ хүснэгт энэ томоохон эх үүсвэр байхгүй. Энэ орж байгаа эх үүсвэрүүдээс дамжуулах шугаман дутагдалтай, хэрэглээн дээрээ хүрэхгүй гэдэг ийм анализ хийсэн. Энэ шугамыг яаралтай зайлшгүй барих нь зүйтэй байна гэдэг ийм тооцоололтой байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Тодруулж асууя Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Тэгэхээр зээлийн өрийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ одоо байгаа тарифаараа бүрэн нөхөх боломжтой юу? Энэ дээр бод би тэр нөгөө ТЭЦ-4 дээр үүссэн шиг тариф нь ингээд өрөө даа, нөхөх боломжгүй гээд ийм асуудал үүсэхгүй юу, эсвэл тарифаа өсгөхгүйгээр даана, эсвэл тэд болгож өсгөж байж энэ өрийг даана, хаана гэсэн тийм тооцоолол ч юу вэ гэж асуусан. Энэ дээр бас тодруулж асууж өгөөч ээ, хариулж өгөөч ээ.

Р.Сэддорж: Өөрийгөө танилцуулаарай. Индрийн микрофон.

О.Хуягцогт: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. Одоогийн тарифаараа бол, одоо тариф тогтоож байгаа аргачлал бол тарифын шинэчлэлүүд хэрэгжүүлэхээр 3 асгийн газрууд дээр удаа дараа яригдаад энэ хэрэгжилт нь түрүүн тодорхой шийдвэрүүдийн улмаас ингээд хойшлогдсон гэж би түрүүний асуултад хариулсан.

Тэгэхээр энэ шалтгааны улмаас одоо бол дамжуулах сүлжээ компанийн тарифыг яг төсвийн байгууллага шиг тогтоож байгаа юм. Зардлыг нь хянаад яг энд ямар үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад ямар санхүүжилт шаардлагатай вэ гэдэг ийм аргачлалаар. Тэгэхээр энийг бид өөрчлөх ийм саналыг боловсруулж зохицуулах хороотой ярьж байгаа. Юу гэхээр бусад улсууд цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчид байдаг ийм монопол энийг хувьчилж болохгүй ийм чиг үүрэг. Тэгэхээр энийг төр хариуцна. Хоёрдугаарт, энэ хөрөнгө.../минут дуусав./

Р.Сэддорж: Индрийн микрофон гүйцээж хариулъя.

О.Хуягцогт: Бусад энэ улсууд дамжуулах шугам сүлжээнийхээ хөрөнгө оруулалтыг тарифын дизайндаа оруулаад, 10 жилийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр гаргаад энийг үе шаттай тарифаа тусгаад ингээд урагшаа харж явдаг ийм тогтолцоотой. Манайх хойшоо харж явдаг. Өнгөрсөн жил ямар зардал гаргасан тэрнээс нь хэтрүүлэхгүй гэдэг ийм тарифын бодлоготой. Тэгэхээр энийг бид урагшаа харсан хөрөнгө оруулалтаа дэмжсэн тарифын дизайныг нэвтрүүлж энийг төлнө гэдэг ийм үндэслэлээр тооцсон. ТЭЦ-3 дээр одоогийн нөхцөл байдал манай тогтолцоо ийм байдал үүсгэж байгаа.

Түрүүний эх үүсвэрийн төслүүд бол одоо хэрэгжээд эхэлчихсэн 7, 8 төсөл, хэрэгжээд ашиглалтад орох гэж байгаа 28 хүртэл нийтдээ 10 эх үүсвэрийн төсөл нийтдээ 2840мвт-аар нэмэгдүүлэх 18 төсөл, арга хэмжээ, энэний эх үүсвэр нь хөрөнгө оруулалт нь 18.9 их наяд төгрөгийн ийм өртөгтэй төслүүд хэрэгжээд явж байна. Тэгэхлээр энэ бид цахилгаан дамжуулах шугам, сүлжээгээ эхний ээлж.../минут дуусав./

Р.Сэддорж: Ажлаа мэдэж байгаа хүмүүс их тодорхой хариулах хэрэгтэй байна шүү. Өртөг өндөр, ач холбогдол нь ямар вэ гэдгийг л асууж байна шүү дээ.

Болчихсон уу? Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа учраас Энхцэцэг гишүүн 1 минут.

М.Энхцэцэг: Баярлалаа. Тэгэхээр эндээс сая та бүхэн ойлгосон бол хар аа ингэж ойлгож байгаа биз Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний одоогийн тариф энэ зээл, өрийг нөхөх боломжгүй. Зөвхөн өнөөдөр дөнгөн данган үйл ажиллагаа явуулж байгаа өдөр тутмынх нь үйл ажиллагааг хаадаг л тийм тарифтай. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ зээлийг авахдаа хаанаас хаах нь тодорхойгүй дамжуулах дээр шийд аваарай гээд ингээд үзчихсэн.

Тэгэхээр ТЭЦ-4 дээр үүссэн шиг асуудал үүсэхгүй гэх баталгаа өнөөдөр байхгүй байна. Уул нь эх үүсвэр барьсан бол жишээ нь энийгээ ашиглаад тэр Баянтээг дээр ч юм уу эх үүсвэр барьсан бол саяын Дашдаваа даргын ярьж байгаа бүх асуудал шийдэгдэнэ. Тэр найдвартай байдал чинь хангагдана, тэр тогтворжил чинь хангагдана, хүчдэл чинь өснө. Бүх юм чинь давхар шийдэгдэх байхгүй юу. Тэгээд дээрээс нь хамгийн гол нь тэр эх үүсвэр чинь баригдлаа маргаашаас нь өөрөө өөрийнхөө өртгийг нөхөөд эхлэх байхгүй юу даа. Орлого олоод эхлэх байхгүй юу. Шугам чинь орлого олохгүй шүү дээ. Тэгээд одоо тарифаа нэмэхгүй, тарифаа боддог механизмд өөрчлөлт оруулахгүй л дамжуулах сүлжээ энийг нөхөж чад.../минут дуусав./

Р.Сэддорж: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Мандхай.

М.Мандхай: Ямар ч байсан энэ төсөл мэдээж явах ёстой гэж бодож байна. Олон ч бас аж ахуйн нэгж, иргэдэд, орон нутгийн цаашдын бас хөгжилд ч гэсэн давуу тал үүсэх нь бол тодорхой. Гэхдээ зүгээр ийм сайн техникийн юмыг сайн ойлгохгүй хүнд яагаад заавал Мандалговиор дамжуулах ёстой байсан юм бэ? Тэр угаасаа тэр одоо байгаа шугам дээр нь ингэж хэлхээ холбож байх ёстой учраас Мандалговиор дамжиж байгаа юм уу? Шууд Арвайхээр рүү дамжуулаад ингээд Улаанбаатараас дамжуулах боломж байгаагүй юм уу? Ингээд заавал дамжихаар чинь илүү өртөг нэмэгдэхээр ийм харагдаж байгаа. Тэр дээр хариулт авчихъя.

Хоёрдугаарт, энэ долларын гэрээ байгаад байна төслийг санхүүжүүлэх 78сая гэж ам.доллар юм байна шүү дээ. Тэгэхлээр энэ төгрөгийн ханш сулраад нөхцөл байдал хүнд байх үед төгрөгийн ханш сулрах юм бол энэ өрийн дарамт үүсэх эрсдэлийг ер нь тооцсон уу энэ Сангийн яам? Хэрэв одоо энэ тариф өсгөхгүй нөхцөл байдал үүсэх сая Энхцэцэг гишүүний бас ярьж байгаа асуудал дээр тариф өсгөхгүй байх нөхцөл үүсэх юм бол үүний алдагдлыг ер нь ямар байгууллага үүрнэ гэж, ер нь хэн үүрнэ, төсөвт дарамт учруулах юм уу, яг яаж, хэн хариуцах вэ гэдэг дээр хариулт өгөөч ээ. Мэдээж энэ 5 жилийн төслийг судлахдаа сайн тооцож эрсдэлийг нь бас тооцсон байлгүй дээ гэж бас бодож байна.

Мөн төсөл хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэл байгаа юу? Тэр дээр эрсдэл хугацаандаа хэрэв хэрэгжиж амжиж дуусаж чадахгүй бол зардал өсөх бас эрсдэл байгаа юу гэдэг дээр хариулт авъя.

Р.Сэддорж: Ажлын хэсэг. Индэр дээр өөрийгөө танилцуулаарай. Дэд сайдын үүрэг гүйцэтгэгч наашаа суучих.

С.Тулга: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар Тулгаа. Гишүүний асуултад хариулъя. Өрийн удирдлагын хуульд заасны дагуу Засгийн газар дамжуулан зээлэхдээ төсөвт аливаа нэгэн дарамт авахгүй байх гэсэн заалтын

хүрээнд Сангийн яам эцсийн зээлдэгч дамжуулан зээлэхдээ ямар валютаар авч байгаа тэр валютаар нь зээлдэг. Өөрөөр хэлбэл, эцсийн зээлдэгч маань ерөнхийдөө ханшийн эрсдэлийг хүлээнэ гэсэн ийм агуулгатай хуулийн заалт байдаг учраас ингэж байгаа.

Түрүүн Энхцэцэг гишүүний асуултад бас нэмэлт хариулт өгөхөд энэ болохлоор SOFR дээр нэмэх нь 1.42 хувь, тэгээд 25 жилийн хугацаатай. 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх. Ерөнхийдөө маш урт хугацааны. Ер нь бол салбарт олдох ер нь нэн бараг хөнгөлөлттэй эх үүсвэр болох ийм тооцоололтой байгаа. SOFR дээр нэмэх нь 1.42 гэхлээр 5 орчим хувьд байна. Арилжааны банкнууд олон улсын санхүүгийн зах зээлээс ерөнхийдөө 3 жилийн хугацаатай их эх үүсвэрийг 9-10 хувиар ингэж босгож байгаа. Энэ талаараа бас давуу талтай.

Олон улсын байгууллагууд олгохдоо ерөнхийдөө эх үүсвэр дээр зээл олгодоггүй байгаа гишүүн ээ. Энэ дамжуулах нь болохлоор бас нөгөө байгаль орчны импакттай гэдэг утгаар бидэнд бол энэ зээл ингээд олдож байгаа. Тэр Арвайхээр рүү яагаад тэгж дамжиж байгааг нь Эрчим хүчний яамнаас.

Дэлхийн банк болон Эрчим хүчний яам, Сангийн яамнаас ажлын хэсэг гаргаад бас дүн шинжилгээ хийсэн байгаа. Тэгээд 31 оноос хойш төсөл хэрэгжинэ. Одоо дамжуулалтаа дамжуулна. Тэр хүртэл ерөнхийдөө тендер зарлана. Тендер бол 28 он хүртэл. Ингээд ерөнхийдөө эрсдэлээ тооцож ер нь хугацаануудаа тавьчихсан байгаа. Тэгэхлээр энэнээс хойш төсөл сунжрахгүй гэсэн ийм дүгнэлт байгаа.

Р.Сэддорж: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Энэ нөгөө эцсийн зээлдэгч энэ нөгөө дамжуулан зээлдүүлж байгаа учраас эцсийн зээлдэгч эрсдэлийг бүрэн хариуцна гэдэг сая хариулт өгчих шиг боллоо Сангийн яам. Тэгээд энэ би түрүүн хэлсэн шүү дээ тариф өсөхгүй тохиолдол үүсвэл яах вэ? Тэгвэл энийг ингээд төсөвт дарамт учрахгүй гэдэг ийм Өрийн удирдлагын тухай хуулиар төсөвт дарамт учрахгүй гэдэг бас хариулт өгчихлөө. Тэгэхлээр би энэ эцсийн зээлдэгч яг энэ асуултад яг бодитой хариулж өгөөч гэж хэлэх гээд байна. Тариф өсөхгүй тохиолдолд яах вэ? Энэ төсөвт тийм дарамт үүсэх юм биш биз дээ? Энэ алдагдлыг хэн хариуцах вэ, яаж хариуцах вэ гэдэг дээр хариулт өгөөч.

Р.Сэддорж: Индрийн микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

Б.Дашдаваа: “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” гүйцэтгэх захирал Дашдаваа байна. Асуултад хариулъя. Мандалговийн, Улаанбаатараас Мандалговийн 220 киловольтын энэ шугам 330 габариттай баригдсан 330 киловольтын габариттай баригдсан дамжуулах чадвар өндөртэй ийм шугам байгаа. Мандалговиос Арвайхээр рүү татахад трассын хувьд хамгийн ойрхон. Ингээд 220 киловольтын шугамаар холбоход схемийн найдваржилт, горимын хүндрэлүүд арилахаар ийм тооцооллоор анх санал оруулсан.

Хархорин нийслэл хоттой холбоотойгоор 600мвт-ын хэрэглээ гарч ирж байгаа. Энэ нь Улаанбаатар хотын Баянхангай баригдах 500 киловольтын шугамаас Хархорин 500 киловольт, цаашаагаа Улиастай 500 киловольт болохоор ийм

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Индрийн микрофон.

Б.Дашдаваа: Тийм, тийм учраас нийслэл хотын хэмжээний бүрэн шилжсэн тохиолдолд энэ бас зайлшгүй 500 киловольтын шугамаар явна. Өнөөдрийн байдлаар Хархорины бүтээн байгуулалтад 220 киловольтын шугам бол үүргээ гүйцэтгэж байгаа гэж үзэж байгаа.

Эцсийн зээлдэгчийн хувьд энэ төсөвт ямар нэгэн дарамт учрахгүй. Дамжуулах сүлжээ компанийн тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо баталж өгч байгаа. Зохицуулах хороон дээр яг энэнтэй адилхан манай дээр нэлээн олон төсөл хэрэгжиж байгаа. Энэ валютын ханшийн зөрүү, бусад алдагдлуудыг тооцоод бид нар зохицуулах хороон дээрээс дамжуулалтынхаа тарифыг батлуулаад ингээд явж байгаа. Тийм учраас дамжуулах сүлжээ компани өөрөө өөрийнхөө тарифт суулгаад энэ алдагдал юм гарвал юу яагаад явна аа

Хугацаандаа хэрэгжих бүрэн үндэслэлтэй байгаа.../минут дуусав./

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя.

Б.Дашдаваа: Урьдчилсан байдлаар олон судалгааны ажлууд хийгдсэн. Дэлхийн банк, Сангийн яам, ингээд Эрчим хүчний яамнаас. 2 аймгийн 7 сумын нутгаар явж байгаа. 2 сумын нутаг дээр бол жаахан хадтай бусад нь трассын хувьд хэвийн. 7 сумын иргэдтэй, ИТХ-аар ороод энэ зөвшөөрөл юмнууд, байгаль орчны үнэлгээ, бусад үнэлгээний ажлуудаар таниулж явсан. Тэгэхээр орон нутгийн зүгээс ямар нэгэн эсэргүүцэл юм гарахгүй. Техник, технологийн хувьд урьд нь хийгдэж байсан ажлуудтай ижил төстэй ийм байгаа учраас бид нар энийг бүрэн хийгдэнэ гэж үзэж байгаа.

Төсөвт өртгийн бид хувьд 1км шугам нь 570 сая, жишиг үнэ бол 550 саяас 580 саяын хооронд байгаа. Тэгэхээр энэ ямар нэгэн байд.../минут дуусав./

Р.Сэддорж: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Манай Эрүүл мэндийн яамныхан тэр трассынхаа ач холбогдлыг арай л жоохон дутуу яриад байна даа. Энэ чинь хамгийн том ач холбогдол нь Улаанбаатарын ачааллыг бууруулж байгаа шүү дээ цаад зорилго нь. Говийн бүсийг хангайн бүстэй ингэж холбосон нь өөрөөр хэлбэл говийн эх үүсвэрийг хангайн бүс рүү чиглүүлж байгаа ийм дамжуулах шугам. Энхцэцэг гишүүн ээ хэрвээ дамжуулах шугам байхгүй бол эх үүсвэр бариад ч хэрэггүй шүү дээ.

Жишээ нь Сэлэнгэ аймаг дээр шинэ эх үүсвэр хувийн хөрөнгө оруулалттай баригдаад дуусаж байгаа энэ жил. Одоо тэрийг холбох ажлыг улс хийж өгөх хэрэгтэй. Шинэ шугам. Тэгэхээр дамжуулах шугамгүйгээр бид нар шинэ эх үүсвэр гээд бодохын ч хэрэг байхгүй. Энэ шугам бол яг тэрүүгээрээ өндөр ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл Улаанбаатараас говийн бүс рүү, эсвэл хангайн бүс рүү чиглүүлэх шугамыг өөрөөр хэлбэл Улаанбаатар дээр ирэх ирээдүйн нэмэлт эх үүсвэр, нэмэлт ачааллыг бүс нутагт нь, тэнд нь дамжуулах шугам хийж өгснөөр ачааллыг бууруулж байгаа ийм асуудал байх.../минут дуусав./

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Заяабал асуултаа татсан. Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа.

Х.Булгантуяа: Би хэдэн асуулт асуух гэсэн юм. Нэгдүгээрт, энэ эрчим хүчний салбарт нийт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэдэн хувь нь, одоогийн байдлаар хэдэн хувь нь байгаа вэ? Эрчим хүчний салбар нэн тулгамдсан асуудал боллоо. Тэгэхээр хэдэн хувь нь байна вэ? Дээрээс нь төрийн өмчит компани, орон нутгуудад эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр энэ зээлүүд нэлээдгүй олгодог. Эгэн төлөлт жоохон тааруухан байгаад байдаг. Эргэн төлөлт нийтдээ ийм төсөл, хөтөлбөрүүд хэчнээн төгрөгийн төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна? Эргэн төлөлт ерөнхийдөө графикайн дагуу явагдаж байна уу, ямархуу байдалтай байна вэ?

Дээрээс нь нэмээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байгаа билүү? Эдийн засаг, хөгжлийн яам чинь уг нь Засгийн газрын тухай хуулиараа хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцах ёстой. Би үүнийг зүгээр гадаадын зээл, тусламжийн төсөл, хөтөлбөр гэж бодохгүй байгаа. Энэ ийм том зээллэгийн төсөл юм чинь энэ хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлттэй явж байгаа гээд Сангийн сайд маань энд эх үүсвэр, дамжуулах шугамын аль нь чухал вэ гэдэг асуудлыг уг нь яриад суух биш Эдийн засаг, хөгжлийн яам үүний нөгөө талд нь ийм эрэлт үүсэх гээд байгаа юм, ийм ачаалал байгаад байгаа юм, энд ийм эх үүсвэр байгаад байгаа юм гээд энэ хөрөнгө оруулалтынхаа нэгдсэн бодлого, төлөвлөлтийг Эдийн засгийн хөгжлийн яам нь энэ тайлбарлаад суух ёстой байсан юм биш үү. Тэр нь хаачаа вэ?

Дээрээс нь эрчим хүчний салбарын ер нь манай Эрчим хүчний яамныхан маань цаашдаа ер нь та бүхэн маань асуудлуудаа яг юу гэж харж байгаа юм бэ? Эдийн засгийн байнгын хороон дээр энэ асуудлуудыг бас нэлээдгүй ярьж байсан юм. Би одоо сайн санахад Тавинбэх сайдыг байхад л орж ирээд л асуудал танилцуулж байхад Эрчим хүчний яам орж ирээд зүгээр зовлонгоо ярих биш яг асуудал шийдлүүдээ ярьж болдоггүй юм уу? Хууль нь юу нь болохгүй байгаа юм бэ? Хөрөнгө оруулалт нь юу нь дутаад байгаа юм бэ? Эс үгүй бол Сангийн яам мөнгийг чинь өгөхгүй байгаа юм уу, эс үгүй бол Улсын Их Хурал хуулийг чинь баталж өгөхгүй байгаа юм уу, ямар асуудал байгаад байгаа юм бэ гэдгийг олон жилийн өмнөөс Улсын Их Хуралд сууж байгаа олон улс төрчид уг нь асууж байсан. Бид нар бүгдээрээ эрчим хүчний инженерүүд биш ч гэсэн дээр ямар ч байсан эх үүсвэр дутагдаад байна, танай дамжуулах шугам сүлжээнүүд чинь муудаад байна гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Улс орон даяар мэдэж байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг удаа дараа яриад байхад ингээд улс төржүүлээд байна, манай салбар руу дайраад байна, бид нар салбараа хамгаалах ёстой, сүүлд нь бүүр инженер биш юм байж юу яриад байгаа юм ч гэж байх шиг бараг ийм байдлаар хандсаар байгаад танай салбар ийм болчихлоо шүү. Миний мэдэхээр 2012, 2013 онд би танай салбарынхантай хувийн хэвшилд ажиллаж байхдаа их холбогдож ажилладаг байсан юм. Тэгэхэд олон улсын инженер, техникийн ажилчид энэ салбар аль хэдийн ачааллаасаа давчихлаа, та нар эх үүсвэр бодохгүй юм уу, энэ шугам сүлжээ хамаг хамаг юмнууд нь хуучирчихлаа гэж ярьж байсан юм. Тэгээд ингээд явсаар байгаад өнөөдөр Монгол Улсын бухимдсан сэдэв болоод эцэс сүүлд нь.../минут дуусав./

Р.Сэддорж: Хариулт индрийн микрофон.

О.Хуягцогт: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбарын тулгамдаж байгаа асуудлыг энэ талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний

талаар Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдаар ахлуулсан, Эрчим хүчний сайд, Сангийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэхийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад авч хэрэгжүүлэх ингээд дунд, богино, урт хугацаанд авч хэрэгжүүлэх нэн тулгамдсан асуудлуудаа эрэмбэлээд ингээд Засгийн газрын 2026 оны 3 сарын 11-ний өдрийн хуралдаан, мөн 3 сарын 18-ны өдрийн хуралдаанаар ингээд хэлэлцүүлсэн. Энэ талаар тодорхой шийдлүүдээ Засгийн газраас Их Хуралд танилцуулах байх аа.

Энд хөндөгдөж байгаа бүх асуудлууд тэнд бас дурдагдсан. Тэгээд богино, дунд, урт хугацаанд ямар бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ, хууль болоод томоохон төслүүд хэрэгжүүлэх, үнэ тарифын бодлогыг яаж өөрчлөх, салбарт засаглал, ил тод байдлыг яаж сайжруулах гээд энэ чиглэлээр тодорхой багц асуудлууд танилцуулагдсан байгаа. Тэгэхээр тэрийг бас Засгийн газраас мэдээлэл удахгүй бас Их Хуралд танилцуулах байх.

Р.Сэддорж: Нэмж хариулъя. Индрийн микрофон. Өөрийгөө танилцуулаад.

С.Тулга: Сангийн яам Санхүүгийн бодлогын газрын дарга Тулгаа. Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбарт нийт 10 төслийн хүрээнд 2.7 их наяд төгрөгийн зээлийн амлалтын дүн байгаа. Үүнээсээ ашиглаагүй үлдэгдэл нь 1.7 их наяд төгрөг байна. Үүнээс яг дамжуулан зээлийн гэрээ байгуулсан үлдэгдэл нь 1.3 их наяд төгрөг байгаа. Дамжуулан зээлийн эргэн төлөлт, үндсэн төлбөрийн эргэн төлөлт 25 оны жилийн эцсийн байдлаар 155.7 тэрбум, хүүгийн төлбөр 69.9 тэрбум, нийтдээ 225 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна. Хугацаа хэтэрсэн үндсэн болон хүүгийн төлбөр бас байгаа. Хугацаа хэтэрсэн дээр үндсэн дээр 189 тэрбум төгрөг, хүү дээр 85.6 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн ийм орлого байна. 10 орчим хувь.

Р.Сэддорж: Булгантуяа гишүүн тодруулж асууна.

Х.Булгантуяа: Түрүүн бас уг нь манай Мандхай гишүүний асуултын гол зорилго нь тийм байх шиг байсан. Эргэн төлөлт хийгдэхгүй яах вэ? Та хэд ТӨК дамжуулан зээлээ хийж байгаа юм байна шүү дээ тээ? ТӨК дараа нь энэ олон улсын төслөө эргэн төлөхийг хариуцах юм байна. Ийм төсөл, хөтөлбөрүүд бид нар бас өмнө нэлээдгүй хийж байсан. Орон нутаг ч гэсэн зарим нь хариуцаж байсан.

Тэгээд орон нутаг бас эргэн төлж чаддаггүй. Заримдаа салбарын сайд нь солигдохоор өмнөх сайдын авсан юм надад хамаагүй хамаагүй гэж үздэг. Засаг дарга нь солигдохоор өмнөх Ардын намын, Ардчилсан намын тавьсан зээл надад хамаагүй гэж хүртэл ярьж байхыг би ч гэсэн өөрөө зөндөө сонсож байсан. Тийм тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ? Тэр ТӨК-ийн даргыг нь солиод ингээд асуудал шийдэгдэхгүй шүү дээ. Тэгэхээр тийм тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ? Төлөгдөж байгаагаасаа илүү их эргэн төлөлт нь цаг хугацаандаа хийгдэхгүй байгаа асуудлууд байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр яг энэ нь эргэн төлөлтийг татвар төлөгчдийн нуруун дээр тавихгүй. Энэ бол эдийн засгийн үр өгөөжтэй төсөл учраас та уг нь эргэн төлөх боломжтой гэж үзэж байгаа юм байна. Үүнийг яаж сахиулах вэ л гэж л асуугаад байгаа юм.

Р.Сэддорж: Хариулт индрийн микрофон.

С.Тулга: Сангийн яам Тулгаа. Гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье. Дамжуулан зээлийн төлбөр дээр Булгантуяа гишүүний ярьсан шиг орон нутаг дээр

бас энэ хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл маш их хуримтлагдаад байсан. Тэгээд Сангийн яамнаас 21 оноос хойш шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлээд орон нутаг дээр байсан 400 гаруй тэрбумын хугацаа хэтэрсэн зээлийг бүрэн барагдуулсан. Одоо ингээд 24 оны жилийн эцсийн байдлаар ерөнхийдөө орон нутаг дээр хугацаа хэтэрсэн үндсэн төлбөр бол бараг бүрэн барагдсан гэж хэлж болно. Хүүгийн төлбөр дээр тодорхой хэмжээний үлдэгдэлтэй байгаа. Эрчим хүчний салбарын тэр тарифын өөрчлөлт гарснаас хойш сүүлийн 2 жил дээр л эргэн төлөлт бол эрс эрчимжсэн. Ингээд энэ 189 гэдэг нь болохлоор 25 оны байдлаар ерөнхийдөө эргэн төлөлт сайжраад 189 болчихсон байгаа. Тэгээд энэ тарифын зохицуулалтын хүрээнд Эрчим хүчний яам, Дэлхийн банкны хийсэн судалгаагаар ерөнхийдөө cashflow анализ хийхэд бүрэн төлөх боломжтой ийм тооцоо гарсан байгаа.

Р.Сэддорж: Нэмж хариулъя. Индрийн микрофон. Тодорхой хариулъя.

С.Тулга: Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар энэ төслийн IRR нь бол IRR буюу эдийн засгийн үр өгөөж нь 18 хувьтай гарсан байгаа. Хүү нь бол 5 орчим хувьтай. Тэгээд энэ дээр нэмээд байгаль орчны нөлөөллийн импактыг нь энэ IRR дээр нь оруулахлаар ерөнхийдөө төсөл 35 хувьтай ингээд маш сайн эдийн засгийн үр ашигтай төсөл гэсэн ийм агуулгаар энэ зээлийг авч байгаа юм.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа.

Б.Пунсалмаа: Монгол Улсын, Монгол Улс олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк гурвын “Эрчим хүч-4” төслийн талаар бид нар ярилцаж байна. Энэ төслөөр Мандалговиос Арвайхээр чиглэлийн 220 киловольтын 278км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөлийг барих гэж байгаа юм. Тэгэхлээр энэ төсөл маань 2024-2028 оны Засгийн газрын төлөвлөгөөнд орж ирчихсэн байсан. 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд орж ирсэн. Гэтэл 2026 оны энэ жил яригдаж байгаа. Яагаад энэ 1 жил ингээд хойшлогдоод ороод ирэв ээ.

Хоёрдугаарт нь энэ зээлийг заавал ингэж 78 сая ам.долларын зээл авч байхаар энийг бид нар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломж, бололцоо байхгүй юу? Энэ нь өөрөө хүүтэй зээл байж байгаа.

Гуравдугаарт нь энэ улсын төсөв дээрээс ер нь энэ төсөлд зориулагдсан нэмэлт дахиад зардал гарах уу гэдэг ийм 3 асуултыг асууя.

О.Хуягцогт: Ажлын хэсэг. Индрийн микрофон.

О.Хуягцогт: Засгийн газрын мөрийн хөтөлбөр Батчимэг гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. Пунсалмаа гишүүн уучлаарай хараа муу. Ингээд хугацааны хувьд процедур Дэлхийн банктай, мөн Сангийн яам, Эрчим хүчний яам хамтарсан ажлын хэсэг ажиллаад өнгөрсөн оны сүүлээр энэ төслүүдийн зээлийн хэлэлцээр ажиллаад Засгийн газрын хуралдаанд оруулаад ингээд Их Хуралд өргөн барих процесс явагдсан. Энэ дээр бас хугацааны хувьд саяын нөгөө 25 он дамжих төлөвлөлт маань ингээд бас хойшилсон тал бий.

Гэхдээ энэ төслийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр бас нэлээн ажиллаж бэлтгэл сайн хангагдсан зураг төсөл, ТЭЗҮ, бусад бэлтгэл хангагдсан тохиолдолд төслийн хэрэгжүүлэх явцад бас алдаа мадаг бага гардаг. Тэгээд тэн дээр хугацаа

төлөвлөснөөс их зарцуулагдсан байна. 78 сая доллар эрчим хүчний сайдын багцад хөрөнгө оруулалт 2026 онд 320 гаруй тэрбум төгрөгийн ийм төсвийн хязгаар тавигдсан. Үүнээс шилжиж байгаа хөрөнгө оруулалтууд бас нэлээдгүй байгаа. Нийтдээ 40 гаруй төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн байгаа.

Тэгээд бид 26 оны төсөв дээр зөвхөн Эрдэнэбүрэний усан цахилгаан станц баригдаж байгаатай холбоотойгоор тэр үйлдвэрлэж байгаа эх үүсвэрийг наашаа дамжуулах шугамын эхний 69км хэсгийг 26 оны төсөвт тусгуулсан. Энэ төсвийн хязгаартаа багтаж ийм шийдэл гаргасан байгаа. Тэгэхээр энэ төсвийн хязгаарт багтаагүй. Түрүүн хэлсэн ер нь дамжуулах шугам сүлжээ бол хэрэгцээ шаардлага бол 4, 5 их наядын хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ байгаа. Гэхдээ энийг улсын төсвөөр Эрчим хүчний сайдын багцад хийгдэнэ гэхээр төсвийн хязгаар боломж байхгүй байгаа.

Улсын төсвийн нийт хөрөнгө оруулалт 3.5 их наяд байгаа энэ жилийнх. Тэгэхээр манайх 10 орчим хувь нь. Үүний Эрдэнэбүрэн, Мянгадын 69км шугамыг оруулахад тэр бол 108 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажил энэ жилийнх дууссан байгаа. Тэгэхээр бид энийг хугацаа алдахгүй хэрэгжүүлэхийн тулд ийм хөнгөлөлттэй, урт хугацааны эх үүсвэрээр даруйхан хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэсэн ийм саналыг холбогдох яамдын түвшинд судлаад оруулж байгаа юм.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Энхцэцэг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Р.Сэддорж: Энэ 78 сая долларыг 287км-т хуваагаад үзэхээр километрийн өртөг нь 978 сая төгрөг болж байна. Ер нь яах вэ тал хээрийн бүсэд зам барихад ойролцоогоор зарим газар 1.2км-ээр тэрбум төгрөгөөр зам барьж байгаа шүү дээ. Тэгээд энэ өртөг дээр бас жоохон анхаарах ёстой болов уу гэж би бодож байна. Тэгэхээр энэ дээр ер нь яг төслийн хэрэгжилтийн шатдаа анхаарах ёстой болов уу гэж би бодож байна. Тийм учраас энэ дээр зориод үг хэлье гэж бодсон.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг

М.Энхцэцэг: Ямар ч байсан яах вэ үнэхээр бага хүүтэй, маш боломжийн нөхцөлтэй ийм сайхан зээл олж ирсэн байна л даа. Энэ үнэхээр сайн. Зүгээр яах вэ энэ олж ирсэн зээлээ чухам шугамд зарах нь зөв байсан уу, эсвэл эх үүсвэрт зарах нь зөв байсан уу гэдэг асуудал бас эргэлзээтэй л дээ. Уул нь үнэхээр тэр Арвайхээр, Баянхонгор гэдэг аймгууд үнэхээр дулаан, цахилгааны хувьд ёстой асар хүнд нөхцөлд байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр уул нь энэ хөрөнгийг тэр аймагт нь эх үүсвэр бариад тэнд нь дулаан, цахилгаан асуудлыг нь шийдсэн бол хамгийн оновчтой хөрөнгө оруулалт байх байжээ гэж ингэж харж байна.

Тэгээд яах вэ Жавхлан сайд бас хэлж байна л даа. Энэ шугам бол Улаанбаатарын ачааллыг бууруулна гээд. Тэгэхээр энэ шугам Улаанбаатарын ачаалалтай ямар ч холбоо байхгүй. Зүгээр яах вэ Улаанбаатар буюу Төв аймагт байгаа эх үүсвэр буюу энд үйлдвэрлэж байгаа цахилгааныг Улаанбаатар, Мандалговь, Мандалговиос Арвайхээр гээд энэ урт шугамаар дамжуулаад аваачаад Арвайхээрийн цахилгааныг хангах ийм л асуудал.

Тэгэхээр угаасаа цахилгааны онол байдаг л даа. Тухайн цахилгаан тухайн хэрэглээг аль болох тухайн орчинд нь эх үүсвэр бариад хангах нь хамгийн алдагдал багатай, хамгийн оновчтой байдаг. Тэгээд уул нь тухайн аймагт нь шийдсэн бол нэгдүгээрт цахилгааныг нь шийдээд, дулааныг нь шийдээд, дээрээс нь саяын тэр нөгөө шугамын алдагдал, хүчлийн уналт өснө гээд ингээд маш их олон ач холбогдолтой зүйлүүд байсан. Тэгээд яах вэ харамсалтай нь ингээд шугамд зарцуулж байгаа юм байна. Тэгээд ТЭЦ-4 шиг ийм өрөө дарж чадахгүй ийм асуудал үүсэх вий дээ гэж маш их болгоомжилж байна.

Тэгэхээр хойшид ийм төсөл дээр маш олон шүүлтүүрээр орж байж үнэхээр шугам зарах уу, эх үүсвэр зарах уу гэдэг дээрээ бас их олон ярьж хэлэлцэж байж шийдэж байх нь зүйтэй юм байна. Тэрнээс энэ дээр би зүгээр л ингээд ямар ч мэргэжлийн хүн харсан ч гэсэн хүүш ээ тэр хаа байсан 200 бараг 300-аад километр 220 шугам барьж байхынхаа оронд тэр Арвайхээр дээр нь нүүрс, Баянтээгийн нүүрс байж байгаа шүү дээ. Тэр Арвайхээр дээр нь 50мвт-ын станцын 50, эсвэл 100мвт-ын станц орог л доо дулааны цахилгаан станц. Тэгвэл тэгэхээр дулааныг нь шийдчихнэ, цахилгааныг нь шийдчихнэ. Тэгэхээр ийм юм руу хөрөнгө оруулах байсан юм байна л гэж ингэж харж байна. Энийг мэргэжилтэн хүний хувьд би л хэлнэ тийм.

Тэгэхээр ингээд эрчим хүчний салбар чинь өрөндөө баригдаад, өтөндөө баригдаж байгаа. Гэтэл тэр өрийг нэмж байгаа нэг юмаа оновчтой юм руу зарсан бол сайн л байсан юм. Үнэхээр энэ зээлийн хүү маш сайхан нөхцөлтэй юм байна 1.42 хувьтай 25 жилтэй гээд. Зээлийн хүү маш сайхан. Тэгэхээр энийг уул нь бүхэл бүтэн аймгийн, 2 аймгийн асуудлыг шийдэх зарцуулсан бол сайн байсан юм байна л гэж ингэж хэлмээр байна. Ингээд зээлийн хувьд бол дэмжиж байгаа.

Р.Сэддорж: Санал хураалтад гишүүд орж ирээрэй Жавхлан сайдыг үг хэлэх дээр нэмье.

Б.Жавхлан: Тийм Энхцэцэг гишүүнд баярлалаа тэгээд зээлийг дэмжиж байгаад. Үнэхээр энэ зээл бол энэ 25 жилийн хугацаатай ... нь 5 жил, тэгээд SOFR дээр нэмэх нь 1.4 гэдэг бол Монгол Улс дахиж бид нар ийм зээл авч чадахгүй цаашдаа. Энэ дөнгөж хөгжиж байгаа ийм буурай оронд өгдөг ийм зээл, нэн хөнгөлөлттэй зээлийн нөхцөл. Тийм, бид нар 2 жилийн өмнөөс буурай орныхоо статусаасаа гарчихсан шүү дээ. Одоо бид нар дунд орлоготой улсын тоонд орчихсон. Одоо цаашдаа бид нарын авах зээлүүд дандаа хугацаа нь богинохон, хүү нь өндөр, дандаа ийм арилжааны болж ирнэ. Энэ ер нь Монгол Улсын авч чадаж байгаа хамгийн сүүлийн, хамгийн таатай нөхцөлтэй л ийм зээл шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтад бэлдье. Хуруугаа дахиж уншуулна гишүүд. Санал хураалт. Саналын томъёоллыг уншъя.

Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-4” төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

59.1 хувиар санал дэмжигдлээ. Баярлалаа. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-4” төслийн зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Уучлаарай Энхцэцэг гишүүн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд байхгүй байгаа учраас Улсын Их Хурлын гишүүн Очирбатаар уншуулъя.

14.22 цаг

Хэлэлцэх асуудал 3.Татан буугдсан “Зоос банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчтэй холбоотой асуудлаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгээс 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Эдийн засгийн байнгын хорооны даргад хандаж “Зоос банк” ХК-ийг 2009 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр албадан татан буулгасан үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл болон хувьцаа эзэмшигч иргэдийн эрхийг хамгаалах асуудлаар хувьцаа эзэмшигч иргэн Б.Цэрэнжавын өргөдлийг үндэслэн ажлын хэсэг байгуулах тухай хүсэлт ирүүлсэн.

Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн энэ мэдээллийг Байнгын хороогоор хэлэлцэж байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүг мэдээллээ танилцуулахыг урьж байна. Гишүүний микрофоныг нээе.

Ц.Баатархүү: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Яах вэ ер нь Эдийн засгийн байнгын хороонд хаяглаад жижиг хувьцаа эзэмшигчид хохирч байна, Байнгын хороо болон Улсын Их Хурлын шийдвэрүүд яг ингээд тодорхой хариу өгөхгүй байна гэсэн гомдол, саналыг нийслэлийн ЧД-ийн иргэн Цэрэнжаваас 119 хуудас бүхий өргөдлийг миний нэр дээр ирүүлсэн.

Өргөдлийг судалж үзэхэд “Зоос банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн асуудал бол 18 жилийн хугацаанд тодорхой биш байна аа. Сүүлийн 3 жил Үндэсний аудитын газрын аудит орсон бас дүгнэлт нь тодорхой биш байна аа. Улсын Их Хурал холбогдох Байнгын хороогоор хэлэлцдэг яг тодорхой шийдвэр ингээд гарахгүй байна гэсэн утга бүхий өргөдлийг ирүүлсэн учраас харьяалагдах Эдийн засгийн байнгын хороонд өргөдлийг шилжүүлж өнөөдөр ингээд хэлэлцүүлж байна.

Гол нь Монголбанк яг тодорхой хариултуудыг өгөх ёстой юм байна. Учир нь энэ асуудлаар 18 жилийн хугацаанд Монголбанк, мөн холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурал дээр ажлын хэсгүүд гарч байсан юм байна. Тэгээд ажлын хэсгүүд гарч байгаад ингээд тодорхой шийдэл гаргадаггүй ямар нэгэн байдлаар ингээд гацчихдаг, үр дүн гардаггүй юм байна. Тэгэхээр өнөөдөр өргөдөл гаргасан Цэрэнжав болон Монголбанкны талууд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралд ирсэн байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Эрдэнэхуяг Монголбанкны Хуулийн газрын Эрх зүйн бодлого, судалгааны хэлтсийн захирал, Амгалан Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч, Б.Цэрэнжав иргэн, хувьцаа эзэмшигч.

Гишүүний мэдээлэлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Эхлээд Монголбанкны мэдээлэл тайлбарыг сонсьё. Индрийн микрофон.

Б.Амгалан: Өдрийн мэнд Монголбанк Санхүүгийн тогтвортой байдлын газрын үүр захирлын үүрэг гүйцэтгэгч Амгалан. Гишүүдэд товч “Зоос” банктай холбоотой товч мэдээлэл хүргүүлье. Товч мэдээлэл хүргүүлье.

Банк маань 99 онд байгуулагдсан. 2005 онд нээлттэй компани болсон. Нээлттэй компани болохдоо 7 хувийг нь 628 хувьцаа эзэмшигч, үлдсэн 93 хувь нь 6 хувьцаа эзэмшигч дээр ийм төвлөрөлттэйгөөр хувьцаа компани болсон байгаа. “Зоос” банкны үйл ажиллагаа бол 2009 оноос хойш доголдож эхэлсэн. Энэ юутай холбоотой вэ гэхээр нөгөө зээлийн чанаргүй актив нэмэгдсэн болон зарим олон улсад нээсэн актив нь хугацаанаас өмнө буцаан дуудагдсан байгаа. Тэгээд энэ активууд дээр, хөрөнгүүд дээр эрсдэлийн сан байгуулсантай холбоотойгоор дүрмийн сан нэмэгдэж буурсан.

Тэгээд 2009 оны 8 сарын 26-нд банкны зүгээс хэсэгчлэн шалгалт ороод 2009 оны 11 сард банкны эрх хүлээн авагч томилогдсон байгаа. Томилогдохдоо Ерөнхийлөгчийн тушаалаар 1 жилийн хугацаатай томилогдож байгаа. Тэгээд томилогдохдоо тухайн үеийн Банкны тухай хуулийн БХА-гийн эрхийн хүрээнд төлөв барагдуулах, өр төлбөрийг барагдуулах ийм чиглэлтэй байгуулсан. Үүнийг дагаад Ерөнхийлөгчийн тушаалаар ажлын удирдамж гарч байгаа.

Татан буухтай холбоотойгоор үндсэндээ “Зоос” банкин дээр үүссэн чанаргүй активыг БХА руу шилжүүлсэн. Банкны эрх хүлээн авагч руу шилжүүлсэн. Үлдсэн өрөөрөө эргэн төлөгдөх боломжтой хөрөнгүүдийг Төрийн банк руу шилжүүлсэн байдаг. Төрийн банк руу шилжүүлэхтэй холбоотойгоор 2009 оны 12 сарын 25-нд Их Хурлын тогтоолоор 100 тэрбум төгрөг хүртэлх үнэт цаасыг гаргах замаар Төрийн банкны дүрмийн санг нэмэгдүүлэх, ингэснээрээ “Зоос” банкны чанаргүй активыг баланст шилжүүлэх ийм шийдвэр гарсан байдаг. Тэгээд энэ шийдвэрийн дагуу “Зоос” банканд нийтдээ “Зоос” банкны БХА-д бол нийтдээ 94 тэрбум төгрөгийн хөрөнгө шилжээд Төрийн банканд 148 тэрбумын хөрөнгө шилжсэн байдаг.

Засгийн газрын зүгээс болон Монголбанкны зүгээс нийтдээ 95.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, санхүүжилт олгосон байдаг. Энэнээс 34 тэрбум нь Монголбанкны барьцаат зээл хэлбэрээр, үлдсэн 53 тэрбум нь Сангийн яамны үнэт цаас арилжаалах замаар энэ дүрмийн санг нь нэмэгдүүлсэн байдаг

БХА томилогдсоноос хойш буюу 2009 оноос хойш өнөөдөр хүртэл нийтдээ 74 тэрбум төгрөгийн актив хөрөнгө төлөгдсөн. Ингэж төлөгдөхдөө энэ Засгийн газрын үнэт цаас төлөгдөхдөө Банкны тухай хуулийн 73 дугаарт заасан дарааллын дагуу төлөгдөж байгаа. Өөрөөр хэлбэл, хадгаламж эзэмшигч төрийн

төрөөс гарсан мөнгө, эцэст нь хувьцаа эзэмшигч буюу хувьцаа эзэмшигч жижиг, том гэсэн ялгаа байхгүй. Тэгээд энэ дарааллаар төлөгдөөд явж байгаа.

Цаашдаа Монголбанкны зүгээс 2 бодлогын арга хэмжээ авах талаар ажиллаж байгаа. БХА-гийн үйл ажиллагааг илүү нэгдэж нийлүүлэх үүний замаар нэгдэж нийлүүлэх ингэснээрээ үйл ажиллагааны зардлыг нь бууруулах. Өөрөөр хэлбэл, саяын энэ зоосны БХА дээр томилогдсон БХА маань мэдээж энэ зээлийг нь төлөх, зээлийг төлүүлэхтэй холбоо үйл ажиллагааны зардал гарч байгаа. Тэгэхээр энэ зардлыг нь ер нь хамгийн бага байлгах түвшинд ийм бодлогын ер нь цаашдаа арга хэмжээ авъя гэсэн ийм бодолтойгоор бид хэд ажлаа хийгээд явж байгаа.

Хоёр дахь нь ер нь урт хугацаандаа энэ Актив удирдлагын компани эрх зүйн орчныг нь гаргаж ирэх ёстой, судлах ёстой гэж үзэж байгаа. 2006 оны төрөөс баримтлах мөнгөний бодлогод энэ актив удирдлагын компанийн эрх зүйн орчныг сайжруулах ийм ажил туссан байгаа. Тэгэхээр энэ актив удирдлагын компанийн үзэл баримтлалыг Монголбанкны зүгээс боловсруулаад эцэслэчихсэн байгаа. Тэгээд шаардлагатай гэвэл гишүүдэд танилцуулах боломжтой.

Тэгэхээр цаашдаа үндсэндээ энэ чанаргүй активыг хурдан, шуурхай төлүүлэх ялангуяа энэ төрөөс олгосон санхүүжилтийг төлүүлэх замаар энэ БХА-гийн үйл ажиллагааг илүү чиг үүрэг тодорхой болгох, ингэснээрээ үйл ажиллагааны зардлыг нь бууруулах, хоёр дахь нь урт хугацаандаа илүү энэ актив удирдлагын компаниар дамжуулж энэ өр төлбөрийг хурдан шуурхай барагдуулах ийм бодлогын арга хэмжээ авахаар ажиллаж байгаа. Бас энэ “Зоос” банкны зээлийн талаар товч дурдвал 32 зээлдэгч байгаа. Үүнээс 21 нь шүүхийн шийдвэр гарчихсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дээр ажил хийгдэж байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дээр нийтдээ хамгийн багадаа 3 жил зарцуулж байгаа. Шүүх шийдвэр гарахад бас 3 жил нийтдээ ингээд хамгийн багадаа 6 жилийн хугацаа шаардагдаж байгаа. Үлдсэн 11 зээлдэгч дээр нөгөө зээлдэгч нь эрэн сурвалжлах ийм ажиллагаа хийгдэж байгаа. Өөрөөр хэлбэл, зээлийг нь төлж барагдуулах иргэн, аж ахуйн нэгж бол одоогийн байдлаар тогтоогдоогүй ийм хүндрэлүүд үүсэж байгаа.

Тэгээд. БХА-г татан буулгах хуульд заасан шаардлага байдаг. Холбогдох журмын дагуу энэ өр барагдуулах үйл ажиллагаа дууссан буюу шүүхийн нэхэмжлэл дууссаны дараа татан буулгадаг байгаа. Баярлалаа.

Цэрэнжав гуайн, иргэн Цэрэнжав гуайтай өргөдөлтэй холбоотойгоор бид хэд судалж үзсэн. Аль болох энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор энэ зарим өр төлбөрийг хурдан, шуурхай төлж барагдуулах өөр хувилбаруудыг санал дотоодын Монголбанкны Хяналт шалгалтын хороогоор бүр хэлэлцэхээр ингээд төлөвлөж байгаа. Гол нь энэ нөгөө Банкны тухай хуулийн 73 дугаарт заасан дарааллын дагуу төлж барагдуулах ийм үүрэгтэй байдаг. Тэгэхээр энэ дарааллыг ямар нэгэн байдлаар алдагдуулахгүйгээр төлж барагдуулах ийм бодлого бид хэд барьж байгаа. Цэрэнжав гуайтай ер нь мэдээлэлтэй байгаа. Бас санал Монголбанканд хэлдэг. Тэгээд энэ саналыг нь бид хэд ер нь ажлын шугамаар судлаад явъя гэсэн ийм бодолтой ажиллаж байгаа.

Л.Соронзонболд: Талуудын байр суурийг ижил, тэгш сонсох зорилгоор Цэрэнжав, иргэн Цэрэнжавын тайлбарыг сонсьё.

Б.Цэрэнжав: Та бүхний өнөөдрийн амрыг эрье. 2009 оны 11 сарын 19-ний эрх хүлээн авагчийг томилж “Төрийн” банк байгуулах Засгийн газрын 11 сарын 19-ний өдрийн тогтоолыг хэрэгжүүлэхээр “Зоос” банк ХК-ийн хөрөнгийг 2 хуваасан байдаг юм 24-ний өдөр.

Хоёр хуваахад хамгийн идэвхтэй активыг нь 400 гаруй тэрбум төгрөгийг нь “Төрийн” банкин дээр байршуулаад тэр үед би зүгээр товч хэлэхэд гүйцэтгэх захирлын ажил хийж байсан Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 25 хувийн төлөөлөл Бен Турнбүүл АНУ-ын өндөр настан иргэн, Нидерландын иргэн Сон Сооронзон нарын бүрэлдэхүүнтэй Отгонбилэг Монголын талаас ийм бүрэлдэхүүнтэй хөрөнгийг хүлээж авч Төрийн банк байгуулсан байдаг юм.

Ингээд 12 сарын 25-нд түрүүн Амгалан захирал бас зөрүүтэй тоо хэлчих шиг боллоо. Шинэ жил болж байхад Дэмбэрэл Их Хурлын дарга “Зоос” банкнийг өөрчлөн зохион байгуулахад зориулж Улсын Их Хурлаас 100 хүртэл тэрбум төгрөгийн гаргах энэ бонд гаргах тогтоол гарсан байдаг юм. Энэ тогтоолыг 10 оны 1 сарын 12-нд Монгол, энэ Засгийн газрын Сангийн яам хэрэгжүүлээд 95 тэрбум төгрөгийн хөрөнгө гаргасан байдаг юм. Энийг 12 онд төлж дуусах ёстой ийм бонд байсан.

Гэтэл өнөөдрийг хүртэл төлж дуусаагүй. Өнөөдрийн байдлаар эрх хүлээн авагч дээр 58 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Энэтэй танилцъя гэхээр танилцуулдаггүй, төлбөр нь хийгддэггүй ингээд Сангийн яаман дээр өртэй, Монголбанкин дээр өртэй байдаг. Энэ төлбөр төлөгдөхгүй байгаа учраас жижиг хувьцаа эзэмшигчдийн төлбөрийг төлж чадахгүй байна гэж ингэж ярьдаг юм.

Ийм учраас бид 23 онд Үндэсний аудитын газар хандаад Үндэсний аудитын газар шалгалт оруулсан Монголбанканд. Тэгсэн асуудал маань нууцын зэрэглэлтэй болж хувирсан. Байгууллагын нууц. Ингээд Төсвийн байнгын хороон дээр нууцын зэрэглэлтэй асуудал хэлэлцээд 25 онд Тэмүүлэн дарга бидэнд мэдэгдсэн байдаг юм. Нууцын зэрэглэлээ гаргах арга хэмжээ авч байна. Тэгж байгаад энэ асуудлыг шийдье. Гэтэл өнөөдрийг хүртэл нууцын зэрэглэлээс гараагүй.

Улмаар өнгөрсөн 25 оны 9 сарын 24-нд Магнайсүрэн аудит, Ганхуяг Төсвийн байнгын хорооны дарга 2 ажлын групп гаргая даа. Энэ ер нь нууцын зэрэглэлтэй бас ил болж болохгүй баримтууд байна. Юу гэж ойлгогдох вэ гэхээр 2009 оны 12 сарын 25-нд 100 хүртэл тэрбум төгрөгийн бонд гаргахад улмаар урьд нь төрийн бонд байгуулах асуудал бол тухайн үеийн нам засгийн тэргүүнүүд хуйвалдаж мөнгө идсэн юм уу даа гэж. Энийг яаж дүгнэж байна гэхээр тэр үед 10 сарын 28-нд Баяр, Сү.Батболдод ажил өгч, Сү.Батболдын Засгийн газар хамгийн түрүүн гаргасан тогтоол нь энэ “Төрийн” банк байгуулах тухай тогтоол байдаг юм. Ингээд энд нь Улсын Их Хурал дээр 95 тэрбум төгрөг зориулж гаргасан.

Гэхдээ өөрчлөн байгуулалт нь “Төрийн” банканд биш шүү. “Зоос” банкны өөрчлөн байгуулалтад. Та бүхэн хууль уншаад үзвэл тэгж бичээтэй байгаа. Тэгээд эргэн төлөгддөггүй. Эрх хүлээн авагчид нь тэр цагаас хойш өнөөдрийг хүртэл 18 жил ажиллаж байна. Эхлээд одоо банкны хэлтсийн дарга хийж байгаа Ариунбат ахлаад ажилласан. Сард 5 сая төгрөгийн цалинтайгаар 2009 оноос хойш ажиллаад сүүлд нь Монголбанкны нэг газрын захирал болоод одоо хэлтсийн дарга хийж байгаа. Мэдэхээр их сайн хүн байгаа. Энийг манай энэ банкны төлөөлөгч сайн мэднэ. Тэгээд эрх хүлээн авагчаа буулгаж чаддаггүй. Банкны хууль,

Компанийн хуулиар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал юм уу тодорхой хурал хийгээд шийдвэр гаргах ёстой байтал гаргаад чадаагүй эд нар. Тэгээд үр тар хийсэн.

Тэгээд бид нар зүгээр байгаагүй. Тэр тухайн үед Их Хуралд хандаад Чулуунбат талийгаач, банкны ерөнхийлөгч Чулуунбатаар ахалсан ажлын групп гаргасан. Энд одоо Их Хуралд сууж байгаа Даваасүрэн адилхан, Сэдванчиг, Фортуна Батбаяр нарын 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын групп гараад дүгнэлт гаргасан байдаг юм. Харамсалтай нь энэ дүгнэлтийг Их Хурал хэлэлцээгүй одоо архивд нь бий Их Хурлын. Яагаад гэвэл сонгууль болоод өөр бүрэлдэхүүн болсон учраас ингээд өнгөрсөн.

Энэний дараа бид нар ярьсаар байгаад З.Энхболдын үед бас ажлын групп гаргасан. Гарамгайсүрэн Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ахлуулсан 7 Их Хурлын гишүүн орсон ажлын групп гараад юу ч хийгээгүй, ямар ч юм шалгаагүй, хийгээгүй, үр дүнгүй чимээгүй тэгээд өнгөрсөн. Ингээд 1915 онд тухайн үеийн Их Хурлын гишүүн байсан Гантөмөрийн Уянга бидний сонгосон гишүүн байсан учраас бид нар асуулга тавиад Их Хурлын тайланг чуулган дээр хэлэлцсэн. Мөн үр дүн гараагүй. Зүгээр хэлэлцээд л байдалтай танилцаад тийм ийм байсан гээд л ингээд л өнгөрсөн. Ийм янзтайгаар Монголбанк асуудалд харьцаад, хандаад өнөөдөр хүрч байгаа. Төрийн банкны 5 давхарт бүтэн 20 хүн ажиллаж байснаа сүүлдээ 2 давхарт нь 5, 6 хүн суугаад өнгөрсөн оны 10 сарын 9-өөс хадгаламжийн бүрэн эрхт төлөөлөгчтэй нэгтгээд одоо үйл ажиллагаа нь явж байгаа.

Энийг юу гэж ойлгох вэ гэхээр тухайн үед Их Хурал шийдвэр гаргаад гаргасан 100 хүртэл тэрбум төгрөгийг тухайн үеийн засаг төрийн эрх баригчид Баяр, Батболд, Их Хурлын дарга Дэмбэрэл, Монголбанкны ерөнхийлөгч Пүрэвдорж, нэн ялангуяа Тэргүүн дэд ерөнхийлөгч байсан Энхбаяр нар хуваан идсэн гэж. Энийг би ямар үндэслэлтэй хэлж байна гэхээр Чулуунбат талийгаач болохоосоо өмнө нэг биш удаа бидэнтэй уулзсан. Тэгээд бид нар буруу юм болсон тухайн үед Төрийн банкиг буруу байгуулсан гэж ингэж үзээд тэгээд дийлээгүй хөөрхий минь бурхан болоод ингээд нэмчихсэн юм. Ийм л юм байгаа юм. Тэгээд тэр тэрбум төгрөгүүдийг тухайн улсууд 10, 10 зохих хэмжээгээрээ хувааж идсэн гэж ингэж ойлгогдож байгаа юм. Яагаад тийм учраас одоо хүртэл төлөгдөхгүй байгаа, тэгээд нууцын зэрэглэлдээ оруулаад сүүлд нь нууц болж хувирдаг Үндэсний аудит бид нар хөөцөлдсөөр байгаад шалгалт хийхээр.

Тийм учраас би та бүхнийг тунгаан үзэж энийг мухарлахгүй бол Монголын хөрөнгийн зах зээл, улмаар банктэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн асуудал хөндөгдөх болов уу гэж бодож байна. Ялангуяа “Зоос” банк гэдэг ХК-ийн жижиг хувьцаа эзэмшигч 625 хүн байдаг юм. Тэрний 125 нь гадаадын иргэд байсан. Одоо тийм олон гадаадын жижиг хувьцаатай компани Монголын биржид байхгүй. Тэрний 86 нь Японы иргэн байсан юм.

Тэгэхээр энэ мэтийн ийм асуудлыг бас бодож үзэх ёстой болов уу гэж бодож байна. Ингээд энэ асуудлыг тодруулаад би энэ мухарлахгүй бол хэдий болтол ингэж явах вэ. Яагаад өнөөдөр Монголын банканд гадаадын хөрөнгө оруулагчид, жижиг хувьцаа эзэмшигчдэд орж ирэхгүй байна. Яагаад гэвэл урд талын бохироо цэвэрлээгүй байгаа учраас одоо хүртэл бас зарим нэг улсууд нь бурханд явчихсан байгаа. Гэхдээ эргээд холбоотой, харьцаатай байдаг юм. Ийм учраас та бүхнийг болгоон үзэж, энэ асуудлыг нэг талд нь гаргах зүйтэй болов уу гэж би бодож

байна. Их Хурал дээр миний мэдэхээс 3, 4 дэх удаагаа хэлэлцэгдэж яригдаж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Монголбанк нэмж тайлбар өгье.

Б.Амгалан: Сая үнэт цаасны эргэн төлөлтийн талаар дурдаж байна. Нийтдээ 41 тэрбум төгрөг эргэн төлөлт хийчихсэн. Тэгээд 54 тэрбумын Сангийн яаманд өгөх ийм өглөгтэй байгаа Зоосны БХА Татварын ерөнхий газарт 3.7 тэрбум төгрөгийн өглөгтэй байгаа. Бид хэд аль болох БХА-даа ямар үүрэг өгч өгч байгаа вэ гэхээр энэ Зоосын Зоос руу шилжсэн энэ лицензийг аль болох эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өөрөөр нь энэ төлүүлэх өөрөөр хэлбэл, нөгөө өөрөөр нь төлүүлэх ийм арга хэмжээ авахаар ажиллаж байгаа. Энэний хүрээнд БХА өөрийн дэргэдээ компани үүсгэн байгуулсан тэгээд энэ үйл ажиллагааг хяналт тавиад явж байгаа.

Монголбанкны зүгээс БХА дээрээ тодорхой давтамжтайгаар хяналт тавьдаг байгаа. БХА бол Банкны тухай хуульд заасан 69 дүгээр зүйл дээр эрх, үүрэг нь заагдсан байдаг учраас яг энэ БХА маань энэ үүргийнхээ, эрхийнхээ дагуу үйл ажиллагаа эрхлээд явдаг байгаа. Түрүүний ярьснаар БХА-гийн үйл ажиллагааны зардлыг бууруулах энэнтэй бол санал нэгдэж байгаа. Зарим нь БХА-г нэгтгэх, нийлүүлэх замаар энэ үйл ажиллагааны зардлыг нь бууруулах. Ялангуяа энэ зээлийн эргэн төлөлт, чанаргүй активын эргэн төлөлттэй нь уялдуулж энэ үйл ажиллагааны зардлыг нь гаргах, энэ цалин тогтоох ийм байдлаар ер нь ажиллах боломжтой гэж харж байгаа.

Тэгээд эцсийн дүндээ энэ актив удирдлагын компанийн эрх зүйн орчин нь төрөөс баримтлах мөнгөний бодлогод туссан байгаа. Тэгэхээр энийг цаашаа ер нь хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болговол ялангуяа ийм жижиг хувьцаа эзэмшигч дээр үүсэж байгаа энэ эрсдэлийг түргэн шуурхай шийдвэрлэх, ялангуяа шүүх дээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дээр энэ хамгийн багадаа 6 ажилд зарцуулж байгаа учраас энэ үйл ажиллагааг илүү түргэн, шуурхай шийдвэрлэх ийм боломжтой гэж харж байгаа. Монголбанкны зүгээс бүх бололцоогоороо дэмжих боломжтой. Ялангуяа түрүүний ярьсан тэр БХА-гийн үйл ажиллагааг нэгтгэн нийлүүлэх, хоёр дахь нь энэ актив удирдлагын компанийн судалгаа бид хэд хийчихсэн бэлэн, үзэл баримтлал бэлэн бол байгаа.

Р.Сэддорж: Нэмж Монголбанкнаас мэдээлэл өгөх гэж байна уу?

Б.Эрдэнэхуяг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монголбанкны Хууль, эрх зүй газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн дарга Эрдэнэхуяг байна.

Цэрэнжав гуайн өргөдөлтэй холбоотой асуудал яг цэвэр Банкны тухай хуулийн зохицуулалтын асуудал байгаа юм. Банкны тухай хуулийн 75 дугаар зүйл дээр татан буулгаж байгаа банкны актив хөрөнгийг мөнгөн хөрөнгө болоод, тэр мөнгөн хөрөнгийг ямар дарааллаар захиран зарцуулж хуваарилах вэ гэдгийг зохицуулсан байдаг. Яг өнөөдрийн байдлаар Засгийн газрын өгөх өглөг буюу тэр Засгийн газрын бондын 58 тэрбум төгрөгийн өглөг Цэрэнжав гуайн хувьцаа эзэмшигчдийн дээр тал дараалалд байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол банкнаас төлбөрийн авлагатай этгээдүүдийн мөнгөн хөрөнгийг бүрэн, төлбөрийг нь бүрэн барагдуулсны дараа хөрөнгө үлдэх юм бол хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн шаардах эрхийн дагуу хуваарилна гэсэн

75 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан байдаг. Энэ зохицуулалтыг баримтлаад явж байгаа учраас өнөөдөр Монголбанкны хувьд ч юм уу, Засгийн газрын хувьд хувьцаа эзэмшигчдийн мөнгийг энэ дарааллыг баримтлахгүйгээр үл харгалзаад хуваарилах нь энэ хууль зөрчих ийм эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэж байгаа.

Хэрвээ энэ дээр яах вэ хууль, эрх зүйн боломж нь ямар байдалтай байна гэхээр хэрвээ Засгийн газраас тодорхой энэ шаардах эрхээсээ гэхээсээ тодорхой хэмжээгээр татгалзаад доор нь байгаа энэ хувьцаа эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг төрөөс гаргасан зардалдаа оруулаад тооцоод ингээд харилцан тохиролцоо хийх юм бол энийг Монголбанкны хувьд 2 этгээдийн хооронд харилцан тохиролцоо хийсэн хэлцлийг үндэслээд энэ бас тодорхой хэмжээний хохирлыг барагдуулах ийм хууль, эрх зүйн боломж өнөөдрийн хувьд байгаа.

Яг өнөөдрийн зохицуулалтын хувьд Засгийн газраас ямар нэгэн байдлаар энэ 58 тэрбумаасаа тодорхой хэмжээгээр татгалзаагүй Банкны тухай хуулийн дарааллыг мөрдөхгүй гэдэг энэ шаардлагыг тавиагүй.../минут дуусав./

Р.Сэддорж: Саяын Монголбанкны болон хувьцаа эзэмшигчийн мэдээлэлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу?

Уянга гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Сая иргэн Цэрэнжавын мэдээллээс харахаар угаасаа Зоос” банкныг татан буулгах үед Засгийн газраас 100 тэрбум төгрөгийн бонд аваад тэгээд тэр мөнгөөрөө санхүүжүүлсэн юм байна гэж ойлголоо шүү дээ. Тэгээд гол нь тэр мөнгөний зарцуулалтын талаарх мэдээллийг авъя гэхээр өгөхгүй байна гэдэг асуудал яриад байна шүү дээ. Энэ дээр дэлгэрэнгүй тайлбар өгөөч гэж нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яах вэ энэ угаасаа энэ банк татан буулгах асуудал угаасаа Монголбанкны өөрийнх нь бүрэн эрхийн асуудал байхгүй юу. Тэгээд Монголбанк өөрөө бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа энэ ажил руу нь хууль зөрчиж Эдийн засгийн байнгын хороо ч юм уу энэ рүү ажлын хэсэг байгуулж орох шаардлага байхгүй байна гэж би харж байгаа юм.

Харин Монголбанканд тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгөөд энэ дээр үнэхээр тодорхой хэмжээнд Засгийн газрын авлага дээр та нарын саяын сүүлд ярьдаг саналаар тийм боломж байдаг юм бол тэр дээр албан бичиг эд нар өгсөн юм байдаг юм уу үгүй юм уу тээ? Энэ талаар бас тодорхой ажлууд жоохон явуулах талаас нь хугацаатай даалгавар өгөх нь зөв болов уу л гэсэн ийм санал байна.

Р.Сэддорж: Монголбанк. Индрийн микрофон.

Б.Амгалан: Асуултад хариулъя 100 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалах Их Хурлын тогтоол гараад 95.1 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалсан байгаа. Үүнээс 33 тэрбум нь Монголбанк, үлдсэн нь Сангийн яам. Эргэн төлөлтийн хувьд бэлэн хэлбэрээр төлөгдсөн. Төлөгдөхдөө энэ Сангийн яамны түрүүний ярьсан дарааллын дагуу төлөгдөж төлөгдсөн байгаа. Одоогийн байдлаар үлдэгдэл нь 54 тэрбум төгрөг, татварын өр төлбөрт 3.7 тэрбум төгрөг, тэгээд бусад иргэнд нийтдээ 12 тэрбум төгрөгийн ийм үлдэгдэлтэй байгаа.

Дарааллын хувьд түрүүн бид хэдийн тайлбарласнаар энэ хуулиа 73 дугаар зүйлд заасан дарааллаар мөрдөж явахар байгаа. Сангийн яамнаас хэрвээ энэ дарааллыг дагуу явахгүйгээр бусад хуулийн этгээд, иргэдийн төлбөрийг барагдуулах энийг зөвшөөрвөл энэ дарааллыг дарааллын дагуу төлөх боломжтой гэж харж байгаа. Тэгэхдээ гол нь хуулийн 73 дугаар, Банкны тухай хуулийн 73-д заасны дагуу энэ дарааллыг Сангийн яамны зүгээс 2015 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд хуралдуулж санал оруулснаараа энэ дарааллаар явах нь зөв гэсэн ийм шийдвэр гарсан байдаг. Тэгэхээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд энэ шийдвэр гарсан байдаг.

Р.Сэддорж: Уянга гишүүн асуултаа асаа татаж байна. Улсын Их Хурлын гишүүн Баатархүү.

Ц.Баатархүү: Монголбанк энэ зарим зүйлүүдээ илүү тодорхой л болгомоор юм шиг санагдах юм. 18 жилийн хугацаанд яг ингээд өгсөн хариулт чинь ийм судалж байна, анхаарч ажиллаж байна гэсэн хариултуудыг өгөөд байгаа юм байна. Нэгдүгээрт Соронзонболд гишүүнтэй би санал нэг байгаад байгаа. Иргэн Цэрэнжав тэргүүтэй жижиг хувьцаа эзэмшигчдэдээ яг шаардлагатай мэдээлэл өгөөд хугацаатай ийм хугацаанд шийдвэрлэнэ гэсэн хугацаа нэгдүгээрт хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт, өргөдөл гаргасан тал бол Сангийн яам нь бас өргөдөл гаргамаар юм шиг санагдаж байна. Сангийн яам өргөдөл гаргаж байгаа тал 2 ойлголцох юм бол Монголбанк дараалалд өөрчлөлт оруулах боломжтой гэсэн зүйл хэлээд байна л даа. Тэгэхээр хоёр тал бол нэг асуудлыг шийдэхдээ хоёр өөр арга замаар ингээд яваад байх шиг байгаа юм. Миний ойлгож байгаагаар өнөөдөртөө энэ асуудалд Монголбанкийг тодорхой хугацаатай ийм хариулт өгөөд Байнгын хорооны зүгээс протоколоор чиглэл өгөөд тэгээд тэр хугацаанд асуудал шийдвэрлэгдэхгүй бол энэ асуудал өөрөө ямар нэгэн тийм өөр шалтгаан байна гэж хардах эрсдэл үүсэж байна л даа. Тэгэхээр Монголбанк бол, Монголбанканд бол Байнгын хороо хугацаатай үүрэг, чиглэл өгөөд протоколоор өгөөд өргөдөл гаргаж байгаа Цэрэнжав тэргүүтэй тал Сангийн яамтай бас ойлголцох, хоёр тал ойлголцох, хугацааны дараалалд өөрчлөлт оруулах тэр зөвшилцөл хийх нь зөв юм болов уу л гэсэн ийм л саналтай байна.

Р.Сэддорж: Тайлбар яваад дууссан байна Цэрэнжав гуай. Боломжгүй. Боломжгүй байна. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн “Зоос банк” ХК-ийг 2009 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр албадан татан буулгасан үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл болон хувьцаа эзэмшигч иргэдийн эрхийг хамгаалах асуудлаар хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн саналаар санал хураалт явуулъя гишүүд.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.11 тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно гэсэн хуулийн заалт байна. Ингээд санал хураалтад бэлдье гишүүд.

Хянан шалгах ажлын хэсэг байгуулахыг, санал хураалтын томьёолол хянан шалгах ажлын хэсгийг хэсэг байгуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

18.2 хувиар санал дэмжигдсэнгүй. Санал хураалт явуулж дууслаа.

Татан буугдсан “Зоос банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчтэй холбоотой асуудлаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна. Гишүүддээ, оролцсон ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Гишүүд шууд чуулганы танхим руу орж санал хураалтад орох юм байна.

15.03 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР